

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1 Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл, дүүрэг хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт;

Хан-Уул дүүргээс хариуцан хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиргачийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийг "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2050" бодлогын баримт бичигтэй уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжилтийг хангулан ажилласан.

Тогтооп шийдвэрийн хэрэгжилт:

2023 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын тогтоол 2, хуралдааны тэмдэглэл 1, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны тогтоол 2, нийслэлийн Онцгой комиссын албан 1 даалгавар тус тус ирж, хяналтын картын маягтын дагуу холбогдох албан тушаалтнуудад танилцуулан хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар 38 тогтоол шийдвэрийн холбогдох 83 заалтыг хяналтад авч, жагсаалтыг Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 03/876 дугаар албан бичгээр Засаг даргын дэргэдэх 28 хэлтэс, албадад хүргүүлсэн. Биелэлтийг нэгтгэж байна.

ТОГТООЛ, ШИЙДВЭР	ТОО	ЗААЛТ
2022 оны жилийн эцсийн байдлаар		
Монгол Улсын хууль	5	25
Улсын Их Хурлын тогтоол	2	3
Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол	1	1
Ерөнхийлөгчийн зарлиг	6	13
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	1	1
Засгийн газрын тогтоол	11	23
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	3	3
Засгийн газрын албан даалгавар	1	1
Ерөнхий сайдын албан даалгавар	1	1
НИЙТ	31	71

Тогтоол шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлсэн зорилт арга хэмжээ:

❖ Монгол Улсын Архивын тухай хууль, Хөгжийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374, 2022 оны 470 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын 2023 оны Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөг Засаг даргын Тамгын

газрын даргаар 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлуулсан бөгөөд хагас жилийн байдлаар 13 арга хэмжээний дундаж биелэлт 51 орчим хувьтай хэрэгжээд байна.

❖ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хөрөг срхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан байгууллагын гүйцэтгэлийн тайлан, нийслэлийн Засаг даргын 2022 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн А/1106 дугаар захирамжийн хавсралтаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам” үн дагуу байгууллагын үйл ажиллагааны тайланг тус тус нэгтгэн боловсруулж, холбогдох албан тушаалтад танилцуулан баталгаажуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст тайлант хугацаанд нь <https://erp.ulaanbaatar.mn/> цахим сайт болон албан бичгээр хүргүүлсэн.

❖ Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтооолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, 2020 оны 42 дугаар тогтооолоор өөрчилсөн “Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн шинэчилсэн найруулгын дагуу албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем <http://erp.ulaanbaatar.mn> системийг Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт 107 байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшил болгон ажиллаж байгаа бөгөөд уг програмыг ашиглахад зөвлөгөө, мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагын хангаж, хяналт тавин ажилласан. Мөн Засаг даргын Тамгын газрын албан бичиг боловсруулалтын үйл ажиллагаанд Стандартчилал Хэмжилэүйн газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-2021 стандартыг мөрдсөн.

❖ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, суурь нөхчлийг бүрдүүлэх, төрийн бүтэээмжийг сайжруулахад чиглэсэн дунд хугацааны зорилтот хөтөлбөр болох “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Төрийн бүтэээмжийн сэргэлт” зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 9 дүүргийн 20 хороонд Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Үйлчилгээний төгөлдөршлийн ISO 23592:2021 стандартыг нэвтрүүлэх төслийг 2023 оны 04 дүгээр сарын 01-нээс 07 дугаар сарын 01-ний хугацаанд хэрэгжүүлэх шатанд явж байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас батлагдсан уг төслийн удирдамжид заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хороодоос санал авч, хорооны Засаг даргын санаачилга, шалгуур үзүүлэлтийн дунд үндэслэн тус дүүргийн 22, 23, 25 дугаар хороодыг төсөлд хамруулахаар сонгосон. Төслийн хүрээнд хороодын албан хаагчид төлөвлөгөөт сургалтуудад хамрагдаж, зөвлөхүүдийн удирдлага дор үйл ажиллагааны зөрүүгийн шинжилгээ, свот шинжилгээ, дотоод аудитын үйл ажиллагааг явуулж, илэрсэн үл тохирлыг запруупах арга хэмжээг хэрэгжүүпэн баталгаажуулалтын шатанд явж байна.



❖ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко – Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор өрнөж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Хан-Уул дүүрэгт 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний календарчилсан төлөвлөгөө, “Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяныг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хуваарийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажиллалаа. Аяны хүрээнд дүүргийн төсвийн 259.6 сая төгрөгийн хөрөнгөөр Айцын ам болон гэр хороололд тарих 8 төрлийн 23,950 ширхэг мод, бут, сөөгийн суулгацыг нийлүүлэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах 4 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Зураг. Аяны нээлтийн арга хэмжээ



Зураг. Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо Айцын аманд хэрэгжүүлж буй ойн төгөл байгуулах талбайн ажилтай танилцах явц



Зураг. Хан-Уул дүүрэг, "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих өдөрлөгийн бэлтгэл арга хэмжээний явц, талбайн хуваарилалт, зохион байгуулалт. Шинээр тарих модны хөрс боловсруулалтад 2 тн компост бордоо ашигласан.



Зураг. Хан-Уул дүүрэг, Айцын ам, 2022 онд мод тарьсан 8 га талбайд 2028 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс цэнэг усалгааг эхлүүлж, 3 удаагийн давтамжтай бордоот усалгаа хийсэн.



❖ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Айцын аманд хэрэгжүүлж буй ойн төгөл байгуулах талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор батлагдсан зураг төслийн дагуу “В” хэсэгт мод тарих 3.5 га талбайд 740 урт метр хамгаалалтын хашаа барьж, 1100 нүх ухаж, усалгаа, арчлалт хамгаалалтад ашиглах 1 гүний худаг өрөмдөж, бэлтгэл ажлыг бүрэн хангасан. Тус талбайд дүүргийн төсвөөр 5 төрлийн 4450, нийслэлээс олгосон 2 төрлийн 2000 ширхэг мод, бут сөөгийг тарина.


Хан-Уул дүүргийн 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны гэр хорооллын 1,500 өрхтэй хамтарч, жимсний болон гоёлын мод, бутны 15,000 ширхэг суулгац тарихаар төлөвлөсөн бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр суулгацыг хүлээн авч, хороодод хуваарилан хүлээлгэж өгсөн.

Зураг. Хан-Уул дүүрэг, гэр хорооллын өрхүүдэд суулгац хүлээлгэж өгөх ажлын явц



Айцын аманд хэрэгжүүлж буй ойн төгөл байгуулах талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 23-ны өдөр хүртэл хугацаанд 60 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, батлагдсан зураг төслийн дагуу "В" хэсгийн 3.5 га талбайд 740 урт метр хамгаалалтын хашаа барьж, 1100 нүх ухаж, 1 гүний худаг өрөмдөж, тус талбайд шинээр 8328 ширхэг мод, бут, сөөгийг тарьж, төгөл байгуулсан.

Зураг. Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Айцын ам, ойн төглийн талбайн В хэсэг



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны A/147 дугаар захирамжийн дагуу 190.0 сая төгрөгийн хөрөнгөөр 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны гэр хорооллын 1500 өрхтэй хамтарч гоёлын болон жимсний модны 15000 ширхэг суулгац тарихаар төлөвлөж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Төлөвлөлтийн дагуу хаврын мод тарилтын ажлын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 21-ний өдөр хүртэл нийт хамрагдах өрхийн 70 хувь буюу 1050 өрхтэй хамтарч 10,500 ширхэг суулгацыг тарьсан.

Зураг. Хан-Уул дүүрэг, гэр хорооллын өрхүүдтэй хамтарч мод тарих ажлын явц



Айцын аманд хэрэгжүүлж буй ойн төглийн талбайн арчлалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ын дэргэд нэмэлтээр нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй 2 иргэдийн булгийг байгуулан ажиллаж байна. Хан-Уул дүүргийн Засаг даргын

2023 оны А/147 дугаар захирамжаар 2022 онд байгуулсан 8 га талбайн арчлалт хамгаалалтын зардлыг Ойжуулалтын ажлын зардлын нормативаар тооцож, төсөв хөрөнгийг шийдвэрлэсэн. Тарилтын дараа бордоот усалгааг 3 удаа хийсэн. Ойн төгелийн В, С хэсэгт 2 гүний худаг гаргасан бөгөөд усны 10 тн багтаамжтай нөөцийн сав, дуслын систем суурилуулахаар ажиллаж байна.

Худалдаа үйлчилгээний чиглэлээр: Шинэчлэн батлагдсан “Зөвшөөрлийн тухай хууль”, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийг танилцуулах сургалтыг нийт 3 удаа зохион байгуулж, худалдаа хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 893 аж ахуйн нэгжийг хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө ёгч, хууль тогтоомж, стандарт шаардлагуудыг багтаасан хялбаршуулсан гарын авлагыг боловсруулан 500 ширхэгийг тарааж, сурталчлан ажилласан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний газруудын үйлчилгээ эрхлэх болон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоохтой холбогдуулан цагийн хязгаарын төсөлд санал авах хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулж, 476 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.



Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд:

“Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн 2 удаагийн хурлаар тамхи худалдах зөвшөөрөл хүссэн 68 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хэлэлцэж, 47 иргэн, аж ахуйн нэгжид тамхи худалдах зөвшөөрөл олгосон.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн <https://khanuuil.mn/il-tod-baidal/> цахим хуудасны ил тод цэс болон мэдээллийн самбарт тамхины зөвшөөрөл авахад бүрдүүлэх материал, тамхи худалдах зөвшөөрөл олгосон иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг тус тус байршуулсан.

Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

Дүүргийн хэмжээнд мал эмнэлгийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх гурвалсан гэрээг 3 газартай шинэчлэн байгуулж гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Мал эмнэлэгийн ажил үйлчилгээний зардалд Засаг даргын неец хөрөнгөөс 13.6 сая төгрөгийг санхүүжүүлэн, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан.

Дүүргийн 2022 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтны тооллогоор тоологдсон 11 аж ахуйн нэгжийн 602136, 73 иргэний 13612 тэжээвэр амьтан, 8 аж ахуйн нэгжийн 901 малын бүртгэлийг мал аж ахуйн салбарын нэгдсэн системд <https://livestock.mofa.gov.mn/login> бүртгэж, баталгаачуулсан.

Мал, амьтны гоц халдварт өвчиний дархлаажуулалтад 270944 мал, амьтан 92.1 хувь, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 9607 бог малыг тус тус хамруулж, хэрэгжилтэд нь тавьж ажилласан.

Дүүргийн Засаг даргын 2023 оны А/286 дугаар захирамжийн дагуу мал, амьтны сэг зэм устгаж, ариутгал халваргүйжүүлэлт хийх ажлыг Мал эмнэлгийн тасаг, “Тохижилт үйлчилээний

тев" ОНӨААТҮГ-тай хамтран зохион байгуулж, 1100 гаруй сэг зэм устгаж, 20200м² талбайд ариутгал халдвартгүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



1.2 "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүрэг хамтран хэрэгжүүлэх 2 бүлэг, 2 зорилго, 3 зорилт, 4 арга хэмжээ 1 дүгээр улиралд 25 хувь, хагас жилээр 58,3 хувьтай хэрэгжиж, хяналт-шинжилгээ, үнэлгээний 2 шалгуур үзүүлэлт 1 дүгээр улиралд 20 хувь, хагас жилээр 50 хувьтай хэрэгжсэн.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны төлөвлөгөөний 1 бүлэг, 2 зорилт, 4 арга хэмжээ 45 хувь, 1 шалгуур үзүүлэлт хагас жилийн байдлаар 100 хувьтай хэрэгжсэн.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 1 бүлэг, 1 зорилт, 3 арга хэмжээ хагас жилээр 50 хувьтай хэрэгжжээ. Хагас жилийн биелэлтийг хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайллантуудын хамт 2023 оны 06 дугаар сарын 02-ны үдирдлагад танилцуулан нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн холбогдох мэргэжилтэнд цахимаар илгээж, тайлагнасан.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:

Агаарын бодхирдлыг бууруулах чиглэлээр: Монгол улсын Засгийн газрын Түүхий нүүрсийг хориглох тухай 62, 223-р тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/1349, А/1357, дүүргийн Засаг даргын А/460, А/532 дугаар захирамжуудын хэрэгжилтийг ханган 2023 онд Хан-Уул дүүргийн Агаарын чанарыг сайжруулах бүсийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 22, 23 дугаар Хөрөөдийн нутаг дэвсгэрт сайжруулсан шахмал түлш борлуулах 50 борлуулалтын цэгийг байгуулж, түгээлт, борлуулалт, нийлүүлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 24-ний өдөр хүртэл хугацаанд хэрэглэгчдийг 20,215 тн сайжруулсан түлшээр хангасан.

График. 2022, 2023 онд борлуулагдсан сайжруулсан шахмал түлшний борлуулалтын байдал



Дүүргийн гэр хорооллын айл өрхүүд “Сайн түлш”-ний картыг 100 хувь ашиглаж байна. Гэр хорооллын өрхүүдээр “Угаар мэдрэгчийг зөв ажиллуулах”, “Угаарын хийн эрсдлээс урьдчилан сэргийлэх” тухай сургалт, хяналт шалгалтыг сар бүр 3-4 удаа тогтмол дүүргийн Цагдаагийн 2-р хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Нийслэлийн нутгийн захирагааны 9 байгууллага, 15 хорооны хэсгийн ахлагч нар, “Таван толгой түлш” ХХК-ны Хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хамтран зохион байгуулж, өдөр бүр мэдээллийг холбогдох шатны дээд байгууллагуудад хүргэсэн.

Зураг. Угаарын хийн эрсдлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт



Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Таван толгой түлш ХХК-тай хамтран 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны өндөр настан ганц бие, олон хүүхэдтэй зэрэг угаартах эрсдэл бүхий 948 өрхөд “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, угаар мэдрэгчээ зөв ажиллуулах, зууханд дулаан баригч бортого суурилуулах талаар сургалтуудыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд угаарын хийн мэдрэгчийг зөв ажиллуулах, зуухны битүүмжлэлийг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч 16228 өрхөөс угаарын хийн мэдрэгчгүй байсан 1969 өрхийг 100 хувь угаар мэдрэгчтэй болгож, 9, 10, 12, 14 дүгээр хорооны өндөр настай 566 иргэний зууханд дулаан баригч бортого суурилуулж өгсөн.



Шуурхай штаб ажиллах хугацаанд 40 иргэн угаарын хийн хордлогод өртөж, эрүүл мэндийн байгууллагад хандаж, 31 иргэн нь тусlamж авч буцсан, 9 иргэн нь хэвтэн эмчлүүлсэн байна.



Үзүүлэлт

Угаарын хийн хордлогод өртөж, эрүүл мэндийн байгууллагад хандсан өрх/хүний тоо

Хүний тоо

15/40

Хүйсээр:	• Эрэгтэй	22/ 55%
	• Эмэгтэй	18/ 45%
Насны ангиллаар:	• Насанд хүрэгчид	21
	• Хүүхэд	19
Тусlamж авч буцсан /Хөнгөн/		31
Угаарын хийн хордлого оноштойгоор хэвтэн эмчлүүлсэн /Дунд, хүнд/		9


Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1561 дүгээр захирамжийн хүрээнд хэрэгжүүлсэн утааны эх үүсвэрийн улсын тоо бүртгэлийн ажлын хүрээнд 100-4200 кВт хүчин чадалтай уурын халаалтын зуухны байгууламжийн 53 зуухыг тоолж, цахим мэдээллийн санд оруулсан.

Зураг. Агаар, бохирдуулагч эх үүсвэрийн зуухны төрлеер гарсан тооллогын дүн



Ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 16228 зуухтай айл өрх тоологдсон нь 2022 оныхоос 862 өрхөөр бага тоологдсон байгаа ба үүнээс дахин төлөвлөлтөд хамрагдсан 452 айл өрх, 410 айл өрх нь цахилгаан халаалт, хийн халаагуур, эрчим хүчний хэмнэлттэй халуугаарт холбогдсон байна.

Зураг.Агаар, бохирдуулагч эх үүсвэрийн сууцны төрлеер гарсан тооллогын дүн



Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1357 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Өлзийтийн шалган нэвтрүүлэх товчоо, Таван толгойн дамжин өнгөрүүлэх товчоо гэсэн 2 чиглэлд дүүргийн Замын цагдаагийн хэлтэс, Цагдаагийн хоёрдугаар хэлтэстэй хамтран хяналт тавьж нийслэлд мэдээ өгч ажилласан. Хан-Уул дүүргийн агаарын чанарыг сайжруулах бүсээр 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 5

дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 16378,11тн нүүрс нэвтэрч, 22644,36тн нүүрс дамжин өнгөрсөн байна.

Зураг. Нүүрс тээвэрлэлтийн хяналт, бүртгэл



- Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр:** Хүнсний аюулгүй байдал, үнийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хүнсний дэлгүүр, худалдааны төвийн үйл ажиллагаа эрхлэгч 486 иргэн, аж ахуйн нэгжид хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулахгүй, дотоод хяналтыг сайжруулах, үнийн мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгаж, иргэдийг үнэн зөв мэдээллээр хangan ажиллах тухай дүүргийн Засаг даргын Тамгын арилгаж, иргэдийг үнэн зөв мэдээллээр хangan ажиллах тухай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 08/119 дугаарт албан бичгийг хүргүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөө өгч, 140 гаруй газарт хяналт шалгалтыг зохион байгуулж, зерчлийг арилгуулан, зөвлөн тусалсан.



Нөөцийн махны худалдааг хүнсний дэлгүүр, сүлжээ 33 дэлгүүрээр жижиглэнгээр 62.2 тонн, өргөтгөсөн худалдаагаар 156.3 тонн нийт 218.5 тонн махыг худалдаалах ажлыг зохион байгуулж, махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийн гомдол санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэсэн.



Өрхийн орлогыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх сонирхолтой иргэдийг дэмжиж улирлын чанартай түр худалдааг 2 байршилд зохион байгуулж, 36 иргэнийг дэмжиж ажилласан.



Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр: Хөдөө аж ахуйг дэмжих зээлд хамрагдах хүсэлтэй газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй 270 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 221 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн аварга фермерт 1, нийслэлийн тэргүүний тариаланчид 4, нийт 5 иргэнийг шагнуулахаар дэмжин тодорхойлсноос "Нийслэлийн тэргүүний тариаланч"-аар дүүргийн 13 дугаар хорооны тариаланч 3.Эрдэнэччуулун, Т.Ламчин нар шалгарсан.



Дүүргийн 13, 14 дүгээр хорооны 180 ерхед 2.8 сая төгрөгийн үнэ бүхий 14 нэр төрлийн 371.2кг хүнсний ногооны үрийг үнэ төлбөргүй олгож, тариалалтыг дэмжин ажилласан.

Дүүргийн нутаг дэвсгэрт хүлэмжийн аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, газар тариалангийн нэгдсэн системд бүртгэж, тарималын сорт, хөрс болон ургамлын арчилгааны мэдээлэлд хяналт тавин ажиллаж байна.



Дүүргийн нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногооны аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн тариалалтыг нэмэгдүүлэх, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, 124 тариалан эрхлэгчийг хамруулсан.



Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт хүлэмжийн аж ахуй эрхэлж буй 80 иргэн, аж ахуйн нэгжийн тариалалт, хүлэмжийн ашиглалт, ургалтын байдалд хяналт тавьж, газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем, хөдөө аж ахуйн зохистой дадал, цахим гарал үүслийн гэрчилгээ, мөнгөн урамшуулалд хэрхэн хамрагдах талаар зөвлөн туслаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө ёгч ажиллаа.

"Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн plant.mofa.gov.mn цахим систем"-д 102.5га талбай бүхий тариан талбай, 188 тариаланчийг тулган баталгаажуулсан.

Тэмс, хүнсний ногооны цахим гарал үүслийн гэрчилгээг 2023 оны эхний хагас жилийн байдлаар 2 аж ахуйн нэгж, 6 иргэний 125.4тн хүнсний ногоонд олгож, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавин ажиллаж байна.



Хүн амын хоол хүнсний талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хоол үйлдвэрлэлд эрүүл ахуйн зохицтой дадлыг нэвтрүүлэх, хүнсний аюулзүй байдлыг хангуулах чиглэлээр:

Хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах, хоолны илчлэг шим тэжээллэг чанарыг сайжруулах, хүнсний эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, ажилтан албан хаагчдын ур чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 334 иргэн, аж ахуйн нэгжийн давхардсан тоогоор нийт 640 ажилтан албан хаагчдыг хамруулсан.



Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд:

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг болон Өрхийн эрүүл мэндийн төвүүд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөө, халдвартын сэжиг илрэх үед авах арга хэмжээний алгоритм, коронавируст халдвартын үед ажиллах 4 алхам, ариутгал халдвартгүйтгэл хийх түр заавар, шуурхай хариу арга хэмжээний S76 багийн ажиллах журам, дуудагдах схем зэргийг шинээр боловсруулан тодотгосон.

"Ковид-19" халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу бэлэн байдлын хүрээнд 200 эмнэлгийн ажилтны томилгоог хийж, эм. эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөц хангальт, хээрийн эмнэлгийн 2 асар, түр байранд 100 ор дэлгэх тооцоог гарган ажилласан. "Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношуур, ариутгал халдвартгүйтгэлийн бодис, эмнэлгийн тоног төхөөрөмж, хүчилтөрөгчийн хангамжийн нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ын дагуу Tandalt.gov.mn програмд бүртгэл хөтөлж хэвшсэн.

Дүүргийн хэмжээнд 2023 онд "Ковид-19" халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 1-р тунд 15, 2-р тунд 24, 3-р тунд 87, 4-р тунд 27, 5-р тунд 4 нийт-157 иргэн . "Ковид-19" халдвараар 367 иргэн, SARS COV-2 виурсын "Омикрон" хувилбарын ХВВ.1.5 дэд хувилбар шинээр 304 иргэн бүртгэгдсэн.


"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилогоо, эмчилгээнд алсын технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх хүрээнд:

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв нь "И-Клиник" ХХК-тай хамтарч, 2023 оны 1 дүгээр сард шинээр үйлчилгээнд нэвтрүүлэн 20 хоногийн хугацаанд эмнэлэгт үзүүлсэн эрүүл мэндийн

хуудсыг цаг алдалгүй хэвлэх, үзлэгийн цаг захиалах, шинжилгээний хариу авах боломжоор хангасан. Програмын хөгжүүлэлтийг нэвтрүүлж, 9242 иргэний 16055 хуудас шинжилгээний хариу хэвлэгдсэн.



Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг нь дүрс оношилгоо факс сервер шинээр үйлчилгээнд нэвтрүүлж эхэлснээр рентген зураг, Эхо зураг хадгалах, эмчийн тэмдэглэл бичих боломж бүрдсэн бөгөөд E-health програм дээр шууд харах, төхөөрөмжүүдийн файлыг дижитал хэлбэрт шилжүүлж хадгалах, эмчийн тэмдэглэл бичих боломж бүрдсэн. E-health программаар 14668 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.



“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд:

“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын 15, 18 дугаар сургуулийн 160 сурагчид эрүүл зөв хооллолт, хөдөлгөөн дасгал, сэтгэл зүйн онцлог сэдэвт сургалтыг БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тасаг, сэтгэл зүйч, өсвөрийн зохицуулагч эмч нарын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, өсвөр үеийн 19 сургагч багшийг бэлтгэсэн.

Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ, зөвлөгөөнд амбулаторийн үзлэгээр өсвөр үеийн кабинетаар болон ерөнхий боловсролын 4 сургуулийн 6432 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж. сүүрь өвчтэй 72 хүүхэд эмчийн хяналтад хянагдаж. 36 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн.

Гэр оронгүй, архины хамааралтай иргэдийг түр хоноглох үйлчилгээнд хамруулдаг “Өлзийт асар” төрийн бус байгууллагад байрлаж буй иргэд болон дүүргийн нутаг дэвсгэрт орон гэргүй, тэнэмэл байдлаар амьдарч буй иргэдийг сурьеэгийн эрт илрүүлэгт хамруулах 2 удаагийн арга хэмжээг Цагдаагийн газар, Эрүүл мэндийн төв, Улаан загалмайн хороотой хамтран зохион байгуулж, 200 гаруй иргэнийг хамруулсан.



Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторит “Эрэгтэйчүүдийн кабинет” байгуулах хүсэлтийг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлж, урологийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх 6 сарын сургалтад хамруулан эрэгтэйчүүдийн үзлэг оношлогоог хийж эхэлсэн.

Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөөт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй

үйлчилгээ үзүүлэх төр, хуеийн хэвешлийн түншлэлд сууринсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх хүрээнд:

2023 оны эхний хагас жилийн байдлаар нийтийн биеийн тамирын чиглэлээр "Хамтдаа хөвшүүлье" 21 хоногийн аяңд 7879 иргэн, хороод болсон срхийн эрүүл мэндийн төвүүдийн ажилтан, албан хаагчдын дундах спортын 3 төрөлт тэмцээнд 253, сургуулийн өмнөх боловсролын багш нарын 3 төрөлт тэмцээнд 620 багш, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 2 арга хэмжээнд 72 иргэн, "Цаг гаргая" аяңд 1,537 иргэн, "Эрүүл мэндийн цахим гүйлт"-ийн тэмцээн 209 иргэн, Аж, ахуй нэгжүүдийн 3 төрөлт тэмцээнд 300 гаруй иргэн, "Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйтлэд 6000 гаруй иргэн, "Хамтдаа алхаад эрүүлжье" аяңд 400 гаруй иргэн, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дундах дүүргийн аврага шалгаруулах "Улаанбаатар лиг" сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөгийн төрлүүдэд 159 багийн 2,738 сурагч, Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох хаврын сорилд 18 байгууллагын 351 ажилтан, албан хаагчид гэх мэт улс, нийслэл, дүүргээс зохион байгуулсан 48 арга хэмжээнд нийт 52868 иргэнийг хамруулсан.



Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд сууринсан тогтолцоонд шилжүүлэх хүрээнд:

Боловсролын салбарт 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтнуудаас үндсэн сургалтад 651 багш, ерөнхий боловсролын 59 сургуулийн 2659 багш, 119 цэцэрлэгийн 1057 багш, нийт 4367 багш зорилтот болон графикт сургалтад хамрагдсан.

2022-2023 оны хичээлийн жилд багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих төлөвлөгөөний хүрээнд 1458 багш 3 удаагийн модуль сургалтад цахимаар хамрагдах захиалгыг Боловсролын мэдээллийн системд бүртгүүлж, хуваарийн дагуу 1259 сургалтад хамрагдсан.

Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангах хүрээнд:

Хан-Уул дүүргийн 7 дугаар хороонд байрлах гэр бүлийн хүчирхийлийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвөөр 52 хүүхэд /эрэгтэй-25, эмэгтэй-27/ үйлчлүүлсэн. 0-18 насны 29 хүүхдийг хамгааллын үйлчилгээ авсан.

Нэг цэгийн үйлчилгээний төв, Хүүхэд тусlamжийн төв үтсанд бүртгэгдсэн 399 дуудлага мэдээлэл бүртгэгдэж, хороодын хамтарсан баг хяналт тавин ажилласнаар 159 дуудлагыг хааж, 240 дуудлага хяналтад байна.

Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон сэтгэл зүйн зөвлөгөө авах хүснэгт гаргасан 158 гэр бүлийн 308 иргэн /хүүхэд-141, насанд хүрэгч-141/-д сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн анхан шатны зөвлөгөө өгч ажилласан.

1.3 Улс, нийслэл, дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалт, зээл тусламж болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөлтийн оновчтой байдал, гүйцэтгэл, чанар, үр дүн;

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжих 42,737.1 сая төгрөгийн 82 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 23 төсөл арга хэмжээ хянагдаж, 14,753.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Үүнээс 21 төсөл арга хэмжээ 12,969.5 сая төгрөг, он дамжин хэрэгжих 2 төсөл арга хэмжээ 1,783.8 сая төгрөг байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022-2023 он дамжин хэрэгжих 1,710.1 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, 2023 онд хэрэгжих 1,473.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ нийт 3,183.7 сая төгрөг батлагдснаас эхний хагас жилд гэрээ байгуулагдаагүй байна.

Дүүргийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй 17 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, санхүүжилт бүрэн олгогдсон. Үүнээс 4 ажилд 1,831.2 сая төгрөг, zuраг төсвийн зөвлөх үйлчилгээний 13 төсөл арга хэмжээнд 258.1 сая төгрөг, б 6 төсөл арга хэмжээнд гүйцэтгэлээр 1,935.0 сая төгрөг нийт 4.024.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр тоогоол, дүүргийн Засаг даргын 2023 оны А/52 дугаар захирамжийн хүрээнд дараах дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн.

Д/д	Дэд хөтөлбөрийн нэр	Нийт төсөв	Зарцуулсан төсөв	Үлдэгдэл төсөв
1	"Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөр	285,000,000	197,246,600	87,753,400
2	"Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөр	70,000,000	4,500,000	65,500,000
3	"Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр	80,000,000	54,068,800	25,931,200
4	"Багш" дэд хөтөлбөр	85,000,000	43,380,684	41,619,316
5	"Ахмадаа дээдэль" дэд хөтөлбөр	475,000,000	237,031,000	237,969,000
6	"Жендерийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөр	30,000,000	-	30,000,000
7	Хорооны хөгжил дэд хөтөлбөр	125,000,000	22,043,000	102,957,000
8	Архигүй орчин дэд хөтөлбөр	25,000,000	-	25,000,000
Нийт		1,175,000,000	558,270,084	616,729,916

"Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн хүрээнд дараах 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, 197,2 сая төгрөгийг зарцуулсан.

1. 313 дугаар цэцэрлэгт "Зөвлөн эдлэл" нийлүүлэх төсөл;
2. 313 дугаар цэцэрлэгт "Гал тогооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл нийлүүлэх төсөл;
3. Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит "Хүүхдийн урлагийн Их наадам" зохион байгуулах төсөл;
4. "Өөрийгөө нээж хөгжүүлэх, сэтгэлзүйн ур чадвараа илэрхийлэх сургалт зохион байгуулах" төсөл;
5. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хагас өнчин, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот өрхийн хүүхдүүдэд бэлэг олгох" төсөл
6. "Богцон дахь соёлын өв" төсөл
7. "Хүүхдийн спортын зуны VII наадамд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлэх" төсөл

"Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрийн хүрээнд ХБНГУ-ын Берлин хотноо 2023 оны 6 дугаар сарын 17-25-ны өдрүүдэд зохион байгуулагдах Тусгай Олимпын Дэлхийн зуны наадамд тус дүүргээс оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлэх төслийг хэрэгжүүлж, 4,5 сая төгрөгийг зарцуулсан.

"Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөрийн хүрээнд дараах 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, 54.1 сая төгрөг зарцуулсан.

1. "Олон Улсын Абалимпийн уралдаанд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх" төсөл
2. "Залуучуудын холбооны уулзалт, хэлэлцүүлэг" төсөл
3. Монголын Хөлбөмбөгийн холбооны "Үндэсний цомын төлөөх-2023" тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлэх төсөл

4. "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих" төсөл
5. "Ажилтай орлоготой залуус" төсөл
6. Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит нисэх, алсын бүсийн сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах төсөл
7. Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит яармагийн бүсийн сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах төсөл



"Багш" дэд хөтөлбөрийн хүрээнд дараах 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 38,3 сая төгрөг зарцуулсан.

1. "Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулиудын багш, ажилчдын спортын 5 төрөлт тэмцээн"
2. Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах төсөл
3. Бүгд Найрамдах Болгар Улсад зохион байгуулагдах "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшах арга зүй" Олон Улсын хуралд оролцох төлөөлөгчийн замын зардалд дэмжлэг үзүүлэх төсөл
4. БНСУ-ын Өмнөд Кёонсанн аймгийн Чанвон дахь Кёоннам Йх сургуульстай хамтарсан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх төсөл

"Ахмадаа дээдэлье" дэд хөтөлбөрийн хүрээнд дараах 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 237,1 сая төгрөг зарцуулсан.

1. "Сар шинийн баярыг утган ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх" төсөл;
2. "Эх орны гурван хэлхээ" төсөл;
3. "Хаврын аяз" нийтийн цэнгээнт бүжийн тэмцээн зохион байгуулах төсөл;
4. "Ахмад настнуудын дунд модон бөмбөгийн тэмцээн зохион байгуулах" төсөл

Хорооны хөгжил дэд хөтөлбөрийн хүрээнд хороодны албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшшуулэх зорилгоор сургалт, арга хэмжээнд хамруулах, ажлын бүтэээмжийг нэмэгдүүлэхэд цахим орчныг үр дүнтэй ашиглах арга зүйгээр ханганд ажилласан. Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын Тамын тазар, Цахим хөгжил, мэдээллийн технологийн тазраас 2022 оны 11 дүгээр сараас 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Хэсгийн ахлагчийн систем"-ийн 3 удаагийн сургалтад Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүд болон 25 хорооны зохион байгуулагч, 220 хэсгийн ахлагчийг хамруулан хэсгийн ахлагчдын ажлын хэрэгцээнд шинээр нэвтрүүлж буй Digital UB аппликэйшний хэрэглээ, бусад холбогдох мэдээлэл, арга зүйгээр ханганд ажилласан. Дээрх системийг ажлын хэрэглээнд нэвтрүүлснээр хэсгийн ахлагч нар өдөр тутмын ажлын тайлан, дээд тазраас явуулж буй судалгаа, санал асуулга, хариуцсан хэсэгт шийдвүүлэхээр дэвшүүлж буй санал, өргөдөл, гомдлыг системд бүртгэж, шийдвэрлэлтийн явцтай танилцах бүрэн боломжтой болсон.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг талуудтай хамтран зохион байгуулах хүрээнд:

Төрөөс хүн амын чиглэлээр 2018-2025 онд баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас "Олон улсын бүлийн өдөр"-ийг утган "Онцлох гэр бүл" шалгаруулах удирдамжийг баталсан бөгөөд Хангэр бүлийн өдөр"-ийг утган "Онцлох гэр бүл" шалгаруулах удирдамжийг баталсан бөгөөд Хангэр дүүргийн хэмжээнд Онцлох 8 гэр бүлийг Оюунлаг гэр бүл, спортлог гэр бүл төрлөөр шалгаруулан цахим мэдээллийн хэрэгслээр алдаршуулж, нийслэлийн онцлох гэр бүл шалгаруулах шалгаруулалтад хүргүүлсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 08 дугаар тогтооолоор сар бүрийн сүүлийн 7 хоногийн Ням гарагийг "Гэр бүлийн өдөр" болгон зарласан.

Гэр бүлийн өдрийг утган Улсын бүртгэлийн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамtran гэрлэлтийн гэрчилгээг гардуулах ёслолын арга хэмжээг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн иргэдийн зохион байгуулсан.

Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулах хүрээнд:

"Хотын соёл-Хорт зурсил" сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 6 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Коллежийн нийт 1045 оюутан хамруулж, "Хотын соёлд - Бидний үйлдэл" сэдэвт илтгэлийн уралдаанд 1, 2 дугаар дамжааны 15 багийн 75 оюутан, б удирдагч багш оролцсон.

Соёлыг түгээн дэлгэрүүлэх, бусдад зэрэгээр нөлөөлөх, соёлтой харилцааг дэмжихэд чиглэгдсэн "Биеэ зөв авч явах соёл" сэдэвт сургалтаар төр, хувийн хэвшлийн нийт 7 байгууллагад 7 удаагийн сургалтаар 206 иргэнийг хамруулсан.

Хотын соёлыг түгээх 3 бичлэг, 16 постерыг төрийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн пэйж хуудас болон иргэд, байгууллагын албан хаагчдын группт байршуулснаар 2478 иргэн хандаж, 327 лайк дарж, 154 шэйр хийгдсэн байна.

2022-2023 оны хичээлийн жилд Соёлын ордны авьяас хөгжүүлэх 6 төрлийн сургалтад эхний хагас жилийн байдлаар 109 хүүхэд хамрагдсан. Сурагчдын өвийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор "Өвийн жим" клубээс "Өв билний бахархал" самбарын үзүүлэн өв соёлоо танин мэдье аялал зохион байгуулж, "Дэлхийн өв ба түүний ач холбогдол", "Дэлхийн өв ба хүрээлэн буй орчин", "Өвийн боловсрол зэрэг сэдвээр 8 удаагийн сургалтад 165 иргэнд хамруулсан.

Ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурхад орчинг бүрдүүлэх хүрээнд:

Тэгш суралцах орчин бүрдсэн хичээлийн байртай ерөнхий боловсролын сургууль 17, тусгай тоноглол бүхий ариун цэврийн өрөөтэй 16, налуу замтай 38 сургууль байна. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй"-н 2 удаагийн сургалтад ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын 158 багш хамрагдлаа.

2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 520, сургуулийн өмнөх боловсролд 160, нийт 680 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна.

Гудамж, зам, талбайн тохижилтын чиглэлээр:

Дүүргийн төсвийн 5.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 1, 2, 5, 7, 8, 10, 13, 14, 16 дугаар хороодын 11 байршилд тохижилтын чиглэлээр 2023 онд шинээр хэрэгжих 8 төсөл арга хэмжээнээс 6 төсөл арга хэмжээ гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатанд, 2 төсөл арга хэмжээ зураг төсөл зөвшилцөх шатанд тус тус хэрэгжиж байна.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 309.2 сая төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй орчны тохижилтын 2 төсөл арга хэмжээний зураг төсөл батлагдсан, талбайн ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөрөөс эхлүүлэхээр бэлтгэл хангаж байна.

Тохижилт, цэцэрлэгжүүлэлт хийх байршлын судалгааг гаргаж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанад хүргүүлж, 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр газар дээр нь ажиллаж, талбайн нөхцөл байдлыг танилцуулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12, 16 дугаар хорооны 3 байршилд тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажил хэрэгжихээр шийдвэрлэгдсэн.



Хан-Уул дүүргийн 1, 2, 3, 10, 11, 12, 13, 14, 15, 17, 18, 23 дугаар хороодод байрлах 24 усан оргилуурын судалгаа, дүүргийн нутаг дэвсгэр дэх хөшөө дурсгал, усан оргилууруудын

засвар, үйлчилгээ, ашиглалтын талаар 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албандаа хүргүүлсэн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/174 дүгээр захирамжийн дагуу тохижилт, засвар, шинэчлэлтийн хүрээнд 1, 2, 10, 13, 22 лугаар хороодол хэрэгжих тохижилтын ажлыг хэрэгжүүлэхээр бэлтгэл хангаж байна.

Хүснэгт. Хан-Уул дүүрэг, тохижилт, засвар, шинэчлэлтийн хүрээнд хэрэгжих ажил

№	Хороо	Ажлын нэр	Төсөвт өртөг, /сая төг./
1	13	7 лугаар хэсэг зам дагуу ойн төгөл бүхий цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	571.2
2	22	Явган замын засвар, шинэчлэлт	85.0
3	2	Явган хүний шат, зам талбайн засвар, шинэчлэлт	30.0
4	10	7-р байрны бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, хуучин тоглоомын талбайн засвар, шинэчлэлт	376.0
5	1	37, 40 дүгээр байрны дунд тохижилт, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил	272.9
Нийт			1,335.1

Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засварын ажлын мэдээлэл: Дүүргийн төсвийн 4.9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хэрэгжих 3 төсөл арга хэмжээний хүрээнд 2, 3, 10, 12, 13, 17 дугаар хороонд нийтийн зориулалттай 13 байрны фасад засвар, дулаалгын ажил гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна.


Хүснэгт. Хан-Уул дүүрэг, Фасад засвар, дулаалга хийх байршлын мэдээлэл

№	Орон сууцны дугаар	Хороо	Байршил	Өрхийн тоо	Ашиглалтад орсон хугацаа	Мэргэжлийн хяналтын дүгнэлттэй эсэх	Давхарын тоо	Орцын тоо
ХОЁРДУГААР ХОРОО								
1	9-р байр	2	ХУД 2 хороо, 19 хороолол	60	1972	2020.01.02-ны өдрийн 02-07-378/01	5	4
ГУРАВДУГААР ХОРОО								
2	1а	3	ХУД 3-р хороо, Дунд гол	24	1994	2020.04.01-ны өдрийн 02-07-135/297	6	1
АРАВДУГААР ХОРОО								
3	62	10	ХУД 10-р хороо	58	1985	2020.02.12-ны өдрийн 02-07-094/136	5	4
4	63	10	ХУД 10-р хороо	58	1985	2020.02.12-ны өдрийн 02-07-094/136	5	4
5	64	10	ХУД 10-р хороо	58	1995	2020.02.12-ны өдрийн 02-07-094/136	5	4
6	1	10	ХУД 10-р хороо	58	1995	2020.02.12-ны өдрийн 02-07-094/136	5	4
7	7	11	ХУД 10-р хороо	116	1995	2020.02.12-ны өдрийн 02-07-094/136	5	8
АРВАН ХОЁРДУГААР ХОРОО								
8	53 байр	12	ХУД 12-р хороо	60	1974	Үгүй	5	4
9	38 байр	12	ХУД 12-р хороо	60	1974	Үгүй	5	4
АРВАН ГУРАВДУГААР ХОРОО								
10	6	13	ХУД 13-р хороо, 1-р хэсэг	24	1988	Үгүй	4	2
11	2	13	ХУД 13-р хороо, 1-р хэсэг	16	1964	2017 оны 05 дугаар сарын 26, 02-01/03	3	2
12	5	13	ХУД 13-р хороо, 1-р хэсэг	16	1964	2018 оны 05 дугаар сарын 26, 02-01/03	3	2
АРВАН ДОЛООДУГААР ХОРОО								
13	8/1-2	17	17-р хороо, 8/4-р байр	15	2000	2021.01.26-ны өдрийн 02-07-265/55	5	1

Явган хүний зам талбайн засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1, 2, 3, 11, 15, 19, 20, 22, 23, 24 дүгээр хорооны 19

байршилд нийт 10.6 км явган хүн зам талбайн засвар, шинэчлэлтийн чиглэлээр 7 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 2 төсөл арга хэмжээ тендер зарлагдсан, 2 төсөл арга хэмжээ үнэлгээний шатанд, 3 төсөл арга хэмжээ 04 дүгээр сарын 15-ны өдрөөс ажил эхлүүлэхээр бэлтгэл хангаж байна.

Зураг. Хан-Уул дүүрэг, явган замын тохижилт, засвар, шинэчлэлтийн ажил



БАЙРШИЛ: 1 дүгээр хороо

- 36, 41, 42 дугаар байр орчим-120 м урт
- 8, 7 дугаар байр орчим – 220м урт
- Жаргалант үйлчилгээний төвөөс 67 дугаар цэцэрлэгт хүртэлх-400м

БАЙРШИЛ: 2А, 12Б, 12В байр орчмын явган хүний замын засвар шинэчлэлт

- ХҮЧИН ЧАДАЛ:** 115 м урт, 1.5м өргөн

БАЙРШИЛ: -3, 4 дүгээр байр орчмын явган хүний замын засвар, шинэчлэлт (2-р хороо/-1А байрнаас 50 дугаар байр хүртэл явган хүний замын засвар, шинэчлэлт

- ХҮЧИН ЧАДАЛ:** 500м урт, 1.5м өргөн

Дүүргийн төсвийн хөрөнгөөр Наадамчдын зам дагуу 41 дүгээр сургуулийн харалдаа явган хүний гарцаас далан руу гарах явган шат, гүүрэн байгууламжийн ажлыг хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан.

Зураг. Хан-Уул дүүрэг, 5 дугаар хороо, Наадамчдын зам дагуу явган шат хийх ажлын явц



Дүүргийн төсвийн 800.0 сая төгрөгийн хөрөнгөөр 13, 16 дугаар хороодод хэрэгжих автобусны буудал, зам талбайн тохижилтын ажил архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах шатанд хэрэгжиж байна.

Зураг. Хан-Уул дүүрэг, автобусны буудлын тохижилт



Авто зам, замын байгууламжийн чиглэлээр: Дүүргийн төсвийн хөрөнгөөр "Хан-Уул зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ-ын авто зам засварын чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх

ажлын төлөвлөгөөг баталж, 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлүүлэхээр бэлтгэл хангаж байна.

Хүснэгт. Дүүргийн төсвийн хөрөнгөөр Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын хэрэгжүүлэх ажлын төс хөмжсс, төсөв

№	Хэрэгжүүлэх ажил	Хороо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төсөвт өртөг
1	Хатуу хучилттай авто зам шинээр тавих	9, 10, 12, 19, 20	км	2,2	3,215.0
2	Авто замын нэхээс		м.кв	2000	170.0
3	Авто зогсоол байгуулах		м.кв	900-1000	163.0
4	Гэр хорооллын гудамж, талбайг хусаж тэгшлэх	4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16	м.кв	120,000	1,200.0
5	Авто замын тэмдэг, тэмдэглэгээ засварлах шинэчлэх				77.5
Нийт					4,825.5

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар батлагдсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах нэгдсэн арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах ажлын хэсэг байгуулагдаж байна.


Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Хотын стандарт, хяналтын газрын бүрэлдэхүүнтэй 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хуралдаж, удирдлага, зохион байгуулалт болоод төлөвлөгөө боловсруулах талаар зөвлөлдсөн.

Тус ажлын хүрээнд дүүрэгт дараах 5 чиглэлээр дэд ажлын хэсэг байгуулахаар тохиролцож, нийслэлийн агентлагуудаас мэргэжилтэн албан хаагчдыг татан оролцуулахаар шийдвэрлэж, холбогдох судалгаа мэдээллийг боловсруулж байна. Үүнд:

1. Барилга, дэд бүтэц, барилгын түр хашаа
2. Хүнс, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал
3. Байгаль орчин, хог хаягдал
4. Гадна тохижилт, орчны аюулгүй байдал
5. Нийтийн эзэмшилийн зам талбай, орц гарц чөлөөлөх

Тазар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд дүүргийн хэмжээнд зөрчилтэй 5284 урт метр хашаа, 3, 10, 19 дүгээр хорооны 155 гараашийг чөлөөлөхөөр тусгагдсан бөгөөд 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдөрөөс эхлэн газар албадан чөлөөлөх тухай шаардах хуудсыг хүргүүлж эхэлсэн.

Тус ажлын хүрээнд дүүргийн 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр 10 дугаар хороо, 49 дүгээр цэцэрлэгийн хойд талд 22 гараашийг буулгаж, газар чөлөөлөх арга хэмжээ авч ажиллалаа.



Хан-Уул дүүрэг, буулгаж газар чөлөөлөх гарааш

№	Хороо	Байршил	Газар чөлөөлөх гараашийн тоо	Талбайн хэмжээ, м.кв
1	3	Энгельсийн гудамж	4	100
2	10	10-р хорооны байрны хойд талд	17	450
3	10	49-р цэцэрлэгийн хойд талд	22	750
4	10	64-р байрны хойд талд	24	880
5	19	Шинэ зуун билэг сургуулийн баруун талд	11	300
6	19	115-р сургуулийн зүүн урагш, 60А байрны зүүн талд	16	500
7	19	115-р сургуулийн зүүн урд, Дэд станцын урд, 54Д байрны зүүн	21	350
8	19	Этүгэн сургуулиас урагш 65, 70А, 85-р байрны урд	38	1200
9	19	58А байрны урд	2	
Нийт			155	4530

Дүүргийн төсвийн 672.9 сая төгрөгийн хөрөнгөөр 16 дугаар хороо Нисэхийн зам дагуу хэрэгжихи борооны ус зайлцуулах шугамын ажлын тендер үнэлгээ хийгдэж байна.

Гэрэлтүүлгийн чиглэлээр: Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны 1.0 тэрбум хөрөнгөөр гэр хороолол, орон сууц хороололд шинээр 360 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажил худалдан авах ажиллагааны шалгаруулах шатанд хэрэгжиж байна.

Дүүргийн орон сууц хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар үйлчилгээнд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд гэрэлтүүлгийн засвар үйлчилгээний ажлын хүрээнд 3 дугаар сард 198 ширхэг гэрэлтүүлэг, 39 ширхэг хазайж далийсан шон засварлаж, 81 метр агаарын сиб кабелиг шинээр татаж, 19 ширхэг гэрэлтүүлгийн самбарт засвар үйлчилгээ хийсэн. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Ажилчны гудамж, Үйлдвэрийн гудамж дагуу таггүй 35, Наадамчдын зам дагуу 85 гэрэлтүүлгийн шонгийн тагжуулж, ил гарсан 311 метр кабелийг цэгцэлж булж, орчны аюулгүй байдлыг хангасан. Гэрэлтүүлгийн асалт 2023 оны 04 дүгээр сарын 07-ны едрийн байдлаар 99.1 хувьтай байна.

1.4 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хетелбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний 5 бүлэг, 9 зорилго, 22 зорилт, 47 арга хэмжээ 1 дүгээр улиралд 38 хувь, хагас жилээр 48 хувь, хяналт-шинжилгээ, үнэлгээний 3 бүлэг, 7 зорилго, 16 зорилтын 36 шалгуур үзүүлэлт 48 хувь, хагас жилээр 68 хувьтай хэрэгжсэн.

Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 4 бүлэг, 15 зорилго, 16 зорилт, 81 арга хэмжээ 1 дүгээр улирлын байдлаар 35 хувьтай хэрэгжсэн бол хагас жилийн байдлаар 63,6 хувьтай хэрэгжсэн.

Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 3 зорилго, 3 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 47 хувь, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт хагас жилийн байдлаар 50 хувьтай хэрэгжиж тайланг нийслэлийн Засаг дартын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнрүү 2023 оны 06 дугаар сарын 07-нд цахимаар илгээсэн.

Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Гэр хорооллыг шинэ үзэл баримтлалын дагуу хөгжүүлж, иргэдэд боломжийн өртөгтэй орон сууцтай болох “Зөв шийдэлтэй” дахин төлөвлөлтийг Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороодод нийт 10 хэсэг 314.75 га талбай буюу 5781 нэгж талбарт 9 төсөл хэрэгжүүлэгч үе шаттайгаар гүйцэтгэж байна.
- 4 дүгээр хороо, 34-р сургууль орчим 16.5 га, 159 нэгж талбарт “Төрийн орон сууцны

корпораци" ТӨҮГ УДДТ 2 ширхэг, дулааны шугамын ажлыг хийж дуусгасан бөгөөд 2023 оны 4 дүгээр сард 16 давхар 4 блок 420 айлын орон сууцны угсралтын ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

-Е-хэсэг 39.9 га, 938 нэгж талбарт "Андын зам констракшн" ХХК 3 блок 360 айлын орон сууц ашиглалтанд оруулж, нийт 5 блок орон сууцны барилга угсралтын ажил хийгдэж байна.

- 5 дугаар хороо, Д хэсэг, 34 га 810 нэгж талбарт "Андын зам констракшн" ХХК 2023 оны 5 дугаар сард барилга угсралтын ажил эхлүүлэхээр ажиллаж байна.

- 41-р сургууль орчим, 10.55 га, 153 нэгж талбарт "Ама констракшн" ХХК 16 давхар, 2 блок орон сууцны суурийн ажил эхлүүлэн барилга угсралтын ажил хийж байна.

- 6 дугаар хороо, Г хэсэг, 54.5 га 1200 нэгж талбарт "Голден мартин" ХХК хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн зураг 100%-ийн гүйцэтгэлтэй дуусгаж батлуулах шатанд ажиллаж байна.

- 7 дугаар хороо, В хэсэг, 40.9 га, 630 нэгж талбарт "Ланкастер" ХХК 2 блок орон сууцны барилга угсралтын ажил эхлүүлэн ажиллаж байна.

- 8 дугаар хороо, А хэсэг, 45.9 га, 756 нэгж талбарт "Монголиан инвестмент корпорейшн" ХХК хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулан, газар чөлөөлөх хэлэлцээрийн шатанд ажиллаж байна.

- А хэсэг, 11.5 га, 134 нэгж талбарт "Ажнай цэгц" ХХК 2 блок 192 айлын орон сууцны барилгын угсралтын ажил хийж байна.

- Б хэсэг, 46.1 га, 788 нэгж талбарт "Ивээлт цамхаг констракшн" ХХК 3 блок 16 давхар орон сууцны барилгын эсэкиз батлуулан, цахилгаан дулааны техникийн нөхцөл хүсэн ажиллаж байна.

- Ү хэсэг, 15 га, 223 нэгж талбарт "Ьаярс ХХК" гүйцэтгэгчээр шалгарсныг Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/156 дугаар захирамжаар цуцалсан бөгөөд 2023 онд тус байршилд төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт зарлахаар төлөвлөж байна.

"Нийслэлийн Орон сууц бодлогын газар"-тай хамтран 2023 оны 3 дугаар сарын 9-ний өдөр, 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдрүүдэд дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны 600 гаруй оршин суугч иргэдтэй "Гэр хорооллын дахин төлөвлөлт"-ийн ажлын явцын талаар мэдээлэл өгөх, санал солилцох уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.



Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд дүүргийн ашиглалтын шаардлага хангахгүй 34 барилгаас 33 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдаж байна. Одоогийн байдлаар 2339 айлын 11 орон сууц ашиглалтад оруулж, 816 өрхийг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангаад байна. 2023 онд АШХНЗОС-ыг дахин барилгажуулах ажлын явц дараах байдалтай байна. Үүнд:

- ❖ ХУД 01-р багц: "Фүжи девелопмент" ХХК Нэхмэлийн 1, 2, 10, 11, 16 дугаар байрыг буулган барилга угсралтын ажил үргэлжилж байна.
- ❖ ХУД 02-р багц: "Харуу констракшн" ХХК Нэхмэлийн 12, 13, 17, 18 дугаар байрыг буулган барилга угсралтын ажил дуусч, далд монтаж, фасад засварын ажил хийгдэж байна.
- ❖ ХУД 04-р багц: "Эм Эм Жи Капитал" ХХК, "Азиан сити" ХХК нэгдэл 2019-2022 онд 2 блок барилга шинээр ашиглалтад оруулан 379 өрхийг орон сууцанд хамруулсан.
- ❖ ХУД 06-р багц: "Мөнх ариун булаг" ХХК Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/159 дугаар захирамжаар батламжтагдан, барилга нураалтын ажлыг гүйцэтгэж байна.

- ❖ ХУД 08-р багц: Сонгон шалгаруулалт зарлагдана.
- ❖ ХУД 09-р багц: "Азиан сити" ХХК Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/255 дугаар захирамжаар батламжлагдсан.
- ❖ ХУД 10-р багц: "Монтед констракшн" ХХК Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/257 дугаар захирамжаар батламжлагдсан.
- ❖ ХУД 11-р багц: Монтеカルо гоулд" ХХК Нийслэлийн Засаг даргын А/80 дугаар захирамжаар батламжлагдсан. Сүрьеэ 20 дугаар байрны дахин төлөвлөлтийн ажил эхлэх шатанд үргэлжилж байна.
- ❖ ХУД 13-р багц: Сонгон шалгаруулалт зарлагдана.
- ❖ ХУД 14-р багц: Архитектур төлөвлөлтийн даалгавар хянан батлуулж, хүлээлгэж өгсөн.
- ❖ ХУД 15-р багц: Архитектур төлөвлөлтийн даалгавар хянан батлуулж, хүлээлгэж өгсөн.
- ❖ ХУД 16-р багц: "Профессионалстрой" ХХК Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/258 дугаар захирамжаар батламжлагдсан.
- ❖ ХУД 17, 18-р багц: Иргэн аж ахуй нэгжээс санал авах шаардлагатай.

"Хот байгуулалт, хөгжлийн газар"-тай хамтран 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр, 5 дугаар сарын 9-ний өдрүүдэд "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах" ажлын явцын талаар мэдээлэл өгөх, санал солилцох уулзалт хэлэлцүүлгийг 1, 2, 3 дугаар хорооны 500 гаруй оршин суугч иргэдийг оролцуулан зохион байгуулсан.



Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/613, А/1031, А/16328 2023 оны А/59 дүгээр захирамжуудаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Явцаар нь авч үзвэл гэрээ байгуулах шатанд – 2, үнэлгээ хийндэж байгаа – 1, тендер зарлах шатанд – 3 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв	2023 онд санхүүжих	Ажлын явц
НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ				
1	Цэцэрлэгийн засвар (Хан-Уул дүүрэг, 12 дугаар цэцэрлэг)	25	25	9 удаа зарласан. Зөвлөмж хүргүүлсэн. 2023.05.30 захиалагч байгууллагаас буцаасан. Тендер баримт боловсруулж байгаа
2	Цэцэрлэгийн засвар (Хан-Уул дүүрэг, 190 дүгээр цэцэрлэг)	75	75	Гэрээ байгуулах эрх олгосон.
3	Камержуулалт	400	400	4 дэх удаагийн зарласан. 2023.04.28-ны өдөр нээлт хийсэн. 2 ААН материал ирүүлсэн. 2023.05.09 татгалзсан. Дахин 2023.05.25 өдөр зарласан
	ДҮН	500	500	
НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН				
1	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохиижилтийн ажил (ХУД)	300	300	Тендер зарласан. 2023.05.29-ний өдөр нээхэд 1 ч ахуй нэгж материал ирүүлээгүй

2	Тохижилтын ажил (ХУД)	300	300	Гэрээ байгуулах эрх олгосон
3	Өрхийн эрүүл мэндэд шаардлагатай тоног төхөөрөмж (ХУД 3, 4, 5, 6, 7, 8, 11 дүгээр хороо)	400	400	Багц-1 170,360.0₮ аж ахуй нэгж материал ирүүлээгүй. Багц 2 67,545.0₮ гэрээ байгуулах эрх олгосон. Багц-3 162,095.0₮ 2023.05.26 нээсэн. 1 аж ахуй нэгж материал ирүүлсэн. Үнэлгээ хийж байгаа
	ДҮН	1,000.00	1,000.00	
	НИЙТ ДҮН	1,500.00	1,500.00	

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр: Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12, 16 дугаар хорооны 3 байршилд тохижилт цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч шалгарч, зураг төсөл боловсруулах шатанд, дүүргийн төсвийн хөрөнгөөр 1, 2, 10, 13, 22 дугаар хороодын 5 байршилд тохижилт, засвар, шинэчлэлтийн ажил гэрээ байгуулагдсан. Тус ажлын хүрээнд дүүргийн 10 дугаар хороо 7 дугаар байрны зүүн тоглоомын талбайг шинэчлэх, бичил цэцэрлэг байгуулах ажил 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхэлж, талбайн газар шорооны ажил хийгдэж байна.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/74 дүгээр захирамжийн дагуу гоёл чимсгэлийн 400,000 цэцгийг үрслүүлж, байжуулах ажлыг 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлүүлэн, хяналт тавьж ажилласан. Дүүргийн 1, 2, 6, 8, 11, 12, 13, 14, 15, 16, 20, 21, 22 дугаар хороодын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 26 байршлын нийт 3823 м.кв талбайд цэцгийн мандал байгуулах ажлыг 2023 оны 06 дугаар сарын 55-ны өдрөөс эхлүүлэн хэрэгжүүлж байна.

Зураг. Хан-Уул дүүрэг, цэцгийн үрсэлгээ, мандал ажлын явц



Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай хамтарч нийтийн эзэмшлийн гудамж, талбайн модыг хэлбэржүүлэх, тайралт хийсэн хэсгийг будах арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд 04 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 1, 2, 3, 5, 11, 20, 21 дүгээр хороодны нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 592 улиас, 15 хайлаасыг стандартын дагуу хэлбэржүүлж, хэлбэржүүлэлтийн ажлыг зогсоосон.

Зураг.Хан-Уул дүүрэг, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн модны хэлбэржүүлэлт



Хэлбэржүүлэлтээс гарсан улиасны мөчрөөр харандаа бэлтгэж, үржүүлэх ажлыг 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс эхлүүлж, 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 6500 ширхэг улиасны харандааг Агро паркийн талбайд тарьсан.

Зураг. Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Агропаркийн талбай, улиасны мөчир тарих явц



Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр:

Дүүргийн хог хаягдлын менежментийг сайжруулах “Хоггүй Хан-Уул” дэд хөтөлбөрийн хүрээнд Япон улсын “SEC” компанийн удирдлагууд дүүргийн хог хаягдлын менежментийн чиглэлээр хамтран ажиллах санал солилцох, дүүргийн хог хаягдлын менежментийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа “Хоггүй Хан-Уул” дэд хөтөлбөрийг танилцуулах уулзалтыг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.

Зураг. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтнүүд, Япон Улсын “SEC” ХХК-ийн төлөөлөгчдийн уулзалт



Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар мэдээлэл өгөх, дахивар хог хаягдал авах сургалт, дахивар авах өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж, нийт 500 гаруй иргэн, 20 гаруй сууц өмчлөгчдийн холбоод, аж ахуй нэгж, байгууллага оролцож, дахин ашиглах боломжтой 13 төрлийн нийт 4974 кг хог хаягдлыг тушааж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэсэн.

Зураг.Дахивар авах өдөрлөг



Дүүргийн Засаг даргын 2022 оны 12 сарын 30-ны өдрийн А/647 дугаар Захирамжаар хог тээврийн гэрээ байгуулахыг хороодын Засаг дарга нарт шилжүүлж, “Хог хаягдал, цуглуулах, тээвэрлэх гэрээ”-ний загварыг шинэчлэн боловсруулсан.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн №2 дугаар шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу “Хог хаягдал, цуглуулах, тээвэрлэх гэрээ”-ний хавсралтаар аж ахуй нэгж, байгууллагын тохижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын зураглал хавсаргаж эхэлсэн. Тус ажлын хүрээнд орчны 50

метрийн зураглалыг дүүргийн хэмжээнд Arc GIS програмд нэгтгэн бүртгэж, мэдээллийн сан үүсгэх ажлыг эхлүүлээд байна. 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 450 аж ахуй нэгж, байгууллагын зураглалыг шинэчлэн гаргасан.

Зурагт. Аж ахуй нэгж, байгууллагын төхижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 мөтр хүртэлих нийтийн эдэлбэр газрын зураглалыг Arc GIS програмд үүсгэсэн мэдээллийн сан

Хог тээвэрлэлт, цуглувалт, парк шинэчлэлт: "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлберийн хүрээнд хог тээврийн машины парк шинэчлэлт хийх он дамжин хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд хог шахаж ачих зориулалтын Хьюндай HD78, HD 170 маркийн 11 автомашиныг 2023 онд хог тээврийн байгууллагуудад хүлээлтэй өгсөн. Дүүргийн Засаг даргын 2023 оны 04 дүүрээр сарын 12-ны 13 дугаар хурлын шийдвэрээр дүүргийн төсвийн 1.2 тэрбум төгрөгөөр хог тээврийн машины парк шинэчлэлт хийх төсөл арга хэмжээ цуцлагдсан. Дүүргийн төсвийн 800.0 сая төгрөгийн хөрөнгөөр 5 ширхэг задгай тэвштэй хог тээврийн машин худалдаж авах ажил гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна.

"Шинэ 7 хоногийг Хоггүй угтья аян"-ны хүрээнд хог тээвэрлэлтэд өдөр бүр, 7 хоног тутам тогтмол хяналт тавьж, хог тээврийн байгууллагуудыг дүгнэн холбогдох мэдээллийг тухай бүр дүүргийн удирдлагууд, УБЗАА-ны ОБХХУХ-т болон хяналтын ТББ-уудад хүргүүлэн ажиллаж байна. Хороодын Засаг дарга нарыг үүрэгжүүлж, хог тээвэрлэлт, гэрэлтүүлгийн асалт, хүн амын шилжилт хөдөлгөөн, хороодоос иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний мэдээллийг өдөр бүр авч, хяналт тавьж ажиллаж байна.



Хан-Уул дүүрэг, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хог тээврийн 4 байгууллагын цуглувалж, тээвэрлэсэн хог хаягдлын тоон мэдээлэл.

Байгууллага	Машины тоо	Рейс	Тээвэрлэсэн хог, тн	Хариуцсан хороо
"Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ	12	858	3,413	9, 10, 12, 13, 14, 16, 21, 25
"Хан-Уул Агро" ОНӨААТҮГ	9	510	2,285	11, 15, 17, 18, 22
"Хан-Эко тээвэр" ААТҮГ	10	855	3,733	4, 5, 6, 7, 8, 24
"Эко хотын тээвэр" ААТҮГ	10	731	2,288	1, 2, 3, 19, 20, 23
Нийт	41	2954	11,719	25 хороо

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс морингийн төвлөрсөн хогийн цэг, авто баазад сар бүр хог тээврийн авто машины жинлэлт, цаг ашиглалтад хяналт тавин ажиллаж байна.

Хөрс, орчны бохирдлыг бууруулах бүх нийтийн их цэвэрлэгээ, ариутгал, халдвартгуйжүүлэлтийн чиглэлээр: Дүүргийн Засаг даргын 2023 оны А/54 дүгээр

захирамжаар батлагдсан "Хоггүй Хан-Уул 2023" аяны хүрээнд дүүргийн хэмжээнд 7 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 7947 аж ахуй нэгж байгууллага, албан ёсны өмчлөгчдийн холбоодын 12,450 хүн оролцож, 715,311 м.кв талбайгаас 368,7 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн байна.

Зураг. Цэвэрлэгээний үйл явцаас



Дүүргийн нутаг дэвсгэрт ариутгах шаардлагатай байршлын судалгааг нэгтгэн үе шаттайгаар ариутгалын ажил хийгдэж байна.

Дүүргийн 5 дугаар хорооны "Арьс ширний 80 айл"-ын нийтийн байрны нүхэн жорлонгийн бохир болон жорлонгоос хальсан бохирдсон хөрсийг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр "Грийт пинус" ХХК-р цэвэрлүүлж, ариутгах ажлыг гүйцэтгүүлсэн. Цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг "Хан-Эко тээвэр" ААТҮГ-р ачиж тээвэрлүүлэв.

Зураг. Хан-Уул дүүрэг, хог цэвэрлэгээ, ариутгал халдвартгуйжуулэлтийн ажлын явц



Дүүргийн 2 дугаар хорооны сургууль, цэцэрлэгийн орчимд байрлах хог ачилтын цэгүүдийг ариутгах ажил хийгдэж байна.

Дүүргийн Засаг Даргын 2023 оны А/286 дугаар Захирамжийн дагуу 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс Хан-уул Тохижилт Үйлчилгээний Төв ОНӨААТҮГ-р 8, 10, 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хуримтлагдсан хур хог, өтгө бууц, малын сэг зэмийг цэвэрлэгээ хийлгэж тонн малын сэг зэм, хог хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэхэд хяналт тавьж цэвэрлүүлсэн.

Зураг. Үхсэн мал, амьтны сэг зэм, хур хог хаягдлыг ачиж, ариутгасан байдал



Зам талбайн цэвэрлэгээ: Дүүргийн авто зам, явган замын цэвэрлэгээ, үйлчилгээг шинээр хариуцаж буй 8 байгууллага болох Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, "Чингэлтэй TYK" ХХК "Охь мандал" ХХК, "Эко эрин тохижилт" ХХК, "Экспресс зам" ХХК, "ТЖН Форестри" ХХК, "Гранд зевс" ХХК-ийн хариуцсан 18 байршлын төв зам, "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ын хариуцсан 102 туслах замын цэвэрлэгээ үйлчилгээнд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Тус ажлын хүрээнд халтиргаа гулгааг арилгах чиглэлээр 3 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг

зохион байгуулж, нийт 18 тонн цас мөсийг цэвэрлэн, халтиргаа гулгаанаас сэргийлэн ажилласан.
Авто замын цас мөсийг цэвэрлэх, халтиргаа гулгааг арилгах зорилгоор 2023 онд 174.5 тн давс, 14 тн бодис цацсан байна.

Зураг. Цас мөс цэвэрлэгээний ажлын явц



Зураг. Зам цэвэрлэгээний ажлын явц



Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын дүүргийн нутаг дэвсгэр дэх гулгаа үүсдэг 10 байршилд буюу өгсүүр зам талбайд нийт 20 ширхэг давсны нөөцийн савыг байрлуулж, Зтн орчим давсаар дүүргэн халтиргаа гулгаанаас сэргийлж ажилласан.

Зураг. Давс, бодисны нөөцийн сав байршуулсан байдал

АДЛ	Хороо	Бодисийн	Байршуулсан нийтийн тоо
1	4	Ханбогд хоткон руу аргадаг уулзвар	2
2	10	Хорооны байр руу аргадаг уулзвар	2
3	10	Морингийн давсаны гар хорооллын зам	6
4	11	Буган халиуны өгсүүр үүр хасан	2
5	14	Гэр хорооллын дундах өгсүүр зам	6
6	16	Гэр хорооллын дундах зам	2
7	19	Грийн хаус уулзваар дээр	2
8	21	ЭхЭМТ ордог уулзвар	2
Нийт			24



Худалдаа үйлчилгээний чиглэлээр: Дүүргийн Засаг даргын дэргэдэх "Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн 2 удаагийн хурал зохион байгуулж, салбарын хэмжээнд тулгамдаж буй 6 асуудлыг хэлэлцэн 235 иргэн, аж ахуйн нэгжийн гомдол, хүсэлтийг шийдвэрлэн хариуг хүргүүлэн ажилласан. Үүнд:

- Гамхи худалдах тусгай зөвшөөрөл хүссэн – 68
- ТҮЦ, ил задгай худалдаа эрхлэх зөвшөөрөл хүссэн – 10
- Иргэдийн өргөдөл, гомдол – 6

Мал аж ахуй эрхлэхийг хориглосон хороодын нутаг дэвсгэрт мал оруулахгүй байх, хяналт тавих чиглэлээр:

Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал оруулахгүй байх, орж ирсэн малыг зөвшөөрсөн бүсэд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр 4 удаагийн арга хамжээ зохион байгуулж, 11.4 сая төгрөгийг үйл ажиллааны зардалд зарцуулж, хэрэгжилтэд хяналт тавьсан.

Дүүргийн Засаг даргын мал аж ахуй эрхлэхийг хориглосон бусэд мал оруулахыг хориглох тухай 2023 оны 08/02 дугаар албан мэдэгдлийг малчин, мал бүхий 208 иргэнд хүргүүлсэн.



“Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бусэд нэвтэрсэн мал, амьтныг гаргах, түр саатуулах журам”-ын төслийн хэлэлцүүлгийг болон холбогдох хууль, тогтоомжийг танилцуулж зөвлөгөө мэдээлэл өгөх уулзалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 150 гаруй иргэнийг хамруулсан.



Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бусэд хариулгагүйгээр бэлчээсэн нийт давхардсан тоогоор 122 иргэний 2694 малыг хориглосон бусээс тууж гарган, 11 иргэний 144 толгой малыг хашаалан, 11 иргэнд Цагдаагийн газраас Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 1.050 сая төгрөгийн тorguuлийн арга хэмжээ авч ажилласан.



Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих ажлын хүрээнд:

Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх бойжуулах төвд 2023 оны эхний хагас жилд өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой, ажлын байргүй 20 иргэнийг элсүүлж, үнэ төлбөргүй ажлын байраар ханган, 6 удаагийн арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 91 сая төгрөгийн борлуулалт хийхэд нь дэмжлэг үзүүлсэн.

Дүүргийн Засаг даргын 2023 оны А/35 дугаар захирамжаар сар шинийн баярт зориулсан “Амар байна уу” үзэсгэлэн худалдаанд дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн түрээсийн төлбөр болох 15 сая төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэн, борлуулалтыг дэмжин ажилласан.

Өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой иргэдэд дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Албан бус насан туршийн боловсролын төвтэй хамтран 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, 50 гаруй иргэнийг хамруулсан. Үүнд :

- Тариалан эрхлэх сонирхолтой иргэдэд “Хүлэмжийн суулгац бэлтгэх” онол, практик хосолсон сургалт
- Хөгжлийн бэрхшээлтэй 11 иргэнд “Бизнесээ эхэл”, “Бизнесээ хөгжүүл” сэдэвт сургалт
- Дүүргийн 12, 13, 14 дүгээр хорооны 20 иргэнд “Төсөл бичих аргачлал” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан.



Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилго, 108 зорилт, 151 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө 1 дүгээр улиралд 30 хувь, хагас жилийн байдлаар 55 хувь, хяналт шинжилгээ үнэлгээний 5 бүлэг, 23 зорилго, 106 зорилт, 164 шалгуур үзүүлэлт 53 хувьтай хэрэгжээд байна.

Дүүргийн ИТХ-ын 2022 оны 12 сарын 16-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдаж, 2023 оны 02 дугаар сарын 14-ны 06 дугаар тогтоосл, 3 дугаар сарын 02-ны 08 дугаар тогтоослоор тус тус тодотгол хийгдэж орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр 41, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр 2 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хороо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжүүлэх дүн	Ажлын явцын тайлбар
Гэрээ байгуулсан /24/					
1	23 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвд жирэмсэн болон эх хүүхдийн үзлэгийн кабинет худалдан авах Эрүүл мэндийн төвийн гадна фасад, гадна тохижилтын засварын ажил	23	160,000.0	160,000.0	Гүйцэтгэгч: “Эн Юу Ти Би” ХХК. Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга нийлүүлсэн. Гүйцэтгэгч: “Гранд авгуш” ХХК гэрээ байгуулсан, Барилгын фасал засварын ажил эхэлсэн.
2	Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажил	20	962,700.0	962,700.0	Гүйцэтгэгч: “Рокгранд” ХХК гэрээ байгуулсан.
3	Буянт-Ухаа сургуулийн спорт заалны засвар	7-р	1,212,400.0	1,212,400.0	Гүйцэтгэгч: “Глаболгейтвэй” ХХК гэрээ байгуулсан. Спорт заалны засварын ажил эхэлсэн. Ажлын явц 30 хувь.
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлэх нэг цэгийн барилгын дотор сантехник дулааны ажил	6	374,000.0	374,000.0	Гүйцэтгэгч: “Жавхлантбогд” ХХК. Барилгын дотор сантехникийн ажил хийгдэж байна. Ажлын явц 30 хувь.
5	Нийтийн зориулалттай орон сууцны дулаалт, фасад засвар /2, 3, 17-р хороо/	2, 3, 17	911,000.0	911,000.0	“Зост өргөө” ХХК шалгарсан. Гэрээ байгуулсан. Фасад засварын ажлын бэлтгэл ажил хангагдаж байна. Ажлын явц 10 хувь.
6	Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга,	12, 13	1,200,000.0	1,200,000.0	Гүйцэтгэгч Юу Би Жи ХХК гэрээ байгуулсан. Фасад

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар

	фасад засвар /12, 13-р хороо/				засварын ажил эхлэх шатанд байна.
8	Борооны ус зайлзуулах шугам сүлжээний ажил	16	672,900.0	672,900.0	Гүйцэтгэгч: "Нүнжиг" ХХК гэрээ байгуулсан. Барилгын ажил эхлэх шатанд байна.
9	Хороодын хэсгийн ахлагч болон төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж худалдан авах	-	300,000.0	300,000.0	Гүйцэтгэгч: "БИ СИ ТИ" ХХК Гэрээ байгуулсан. Тоног төхөөрөмж нийлүүлэх шатанд байна. Ажлын явц 70 хувь.
10	Мод талбайд үржүүлгийн ашиглах механизмыг трактор, худалдан авах	-	215,000.0	215,000.0	Гүйцэтгэгч: "Монтех дистрибуишн" ХХК Гэрээ байгуулсан. Трактор нийлүүлэх шатанд байна. Ажлын явц 50 хувь.
11	Соёлын ордоонд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	19	265,800.0	265,800.0	Гүйцэтгэгч: "Эм И Си Ти Эс" ХХК Гэрээ байгуулсан. Тоног төхөөрөмж нийлүүлэх шатанд байна. Ажлын явц 50 хувь.
12	Хог тээврийн машин худалдан авах	-	2,000,000.0	2,000,000.0	Гүйцэтгэгч "Би Ти Эс Эм" ХХК гэрээ байгуулсан.
13	Цагдаагийн хэлтэст шаардлагатай техник хэрэгсэл худалдан авах	20	99,400.0	99,400.0	Гүйцэтгэгч: "Голден хоул" ХХК Гэрээ байгуулсан. Тоног төхөөрөмж нийлүүлэгдэх шатанд байна.
14	Ажилчны алдар талбайн тохижилт /2-р хороо/	2	903,700.0	903,700.0	Гүйцэтгэгч: Ханбилүү ХХК гэрээ байгуулсан. Тохижилтын ажил эхлэх шатанд байна.
15	75 дугаар сургуулийн гадна спорт талбайн тохижилт /2-р хороо/	2	761,000.0	761,000.0	Гүйцэтгэгч: "Лантмон" ХХК Гэрээ байгуулсан. Тохижилтын ажил эхлэх шатанд байна.
16	Явган хүний зам талбайн засвар, шинэчлэл /1, 2, 3-р хороо/	1, 2, 3	708,500.0	708,500.0	Гүйцэтгэгч: "Нутгийн баруун мод" ХХК гэрээ байгуулсан. Явган замын ажил эхэлсэн. Ажлын явц 20 хувь.
17	29, 73-р цэцэрлэгийн гадна талбайн тохижилтийн ажил /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг/	5, 7	536,000.0	536,000.0	Гүйцэтгэгч: "Гардэнсити" ХХК гэрээ байгуулсан. Тохижилтын ажил эхэлсэн. Ажлын явц 10 хувь.
18	Дэнжийн цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, тохижилтийн ажил/8-р хороо/	8	500,000.0	500,000.0	Гүйцэтгэгч: Прогресс Интер Медишин ХХК гэрээ байгуулсан. Тохижилтын ажил эхлэх шатанд байна.
19	Гадна талбайн тохижилтийн ажил /10-р хороо 60/2 дугаар байр,	10, 13, 14	935,000.0	935,000.0	Гүйцэтгэгч: "Велко инк" ХХК гэрээ байгуулсан.

	13-р хороо 144-р цэцэрлэг, 14-р хороо 59-р сургууль/				Toхижилтын ажил эхалсэн. Ажлын явц 20 хувь.
20	Явган хүний зам талбайн засвар, шинэчлэл /23, 24-р хороо/	23, 24	690,000.0	690,000.0	Гүйцэтгэгч: "Жаргалант дулаан" ХХК гэрээ байгуулсан. Явган замын ажил эхэлсэн. Ажлын явц 10 хувь.
21	15, 16, 20, 21 дүгээр хороодын шилэн кабель татах ажил	-	120,000.0	120,000.0	Гүйцэтгэгч: "Виртуал линк" ХХК гэрээ байгуулсан. Шилэн кабел татах ажил хийгдэх шатанд байна.
22	Нэгдсэн эмнэлгийн мэс заслийн тасгийн шинэчлэл засварын ажил	23	375,000.0	375,000.0	Ти Эйч эн ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд байна. 2023.05.29-нд зөвлөмж хүргүүлсэн.
23	Камерын нэгдсэн хяналтын төв рүү шилэн кабел татах, засвар тохижилт	16	75,000.0	75,000.0	Нэмэлт гэрээ байгуулах шатанд байна.
24	Цэцэрлэгийн барилга	Нисэхи йн бус	2,200,000.0	1,000,000.0	Гүйцэтгэгч: "Инерци" ХХК гэрээ байгуулсан.

Худалдан авах ажиллагааны шатанд /15/


25	Цахилгааны хүчдэл сайжруулах /12-р хороо/	12	146,000.0	146,000.0	2023.05.26-нд нээлт хийсэн.
26	Чингисийн хүрээний авто замаас эко ахмалын сувилап хүртэлх авто замын ажил	8	3,526,600.0	1,063,300.0	2023.05.15-нд нээлт хийсэн. 7 аж ахуй нэгж материал ирүүлсэн.
27	Хяналтын камерын нэгдсэн төв, нисэх, алслагдсан бүсийн камержуулалтын зураг, төсвийн ажил	-	70,000.0	70,000.0	2023.04.15, 2023.05.15-нд тендер зарласан. 2023.06.05-нд нээлт хийх байсан бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1 дэх хэсгийн дагуу худалдан авах ажиллагааг зогсоон.
28	2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засварын ажлын зураг төсөв	Төвийн бус	150,000.0	150,000.0	2023.04.10, 2023.05.05-нд тендер зарласан. 2023.06.05-нд нээлт хийх байсан бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1 дэх хэсгийн дагуу худалдан авах ажиллагааг зогсоон.
29	2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засварын ажлын зураг төсөв	Яарма гийн бус	100,000.0	100,000.0	2023.04.24, 2023.05.15-нд тендер зарласан. 2023.06.30-нд нээлт хийх байсан бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1 дэх хэсгийн дагуу худалдан авах ажиллагааг зогсоон.
30	2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засварын ажлын зураг төсөв	Нисэх, алслаг дсан бус	150,000.0	150,000.0	2023.04.10, 2023.05.05-нд тендер зарласан. 2023.06.05-нд нээлт хийх байсан бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1 дэх хэсгийн дагуу худалдан авах

31	Наран хотхон, 8, 18-р байрны гадна талбайн тохижилт, засвар шинэчлэлтийн ажил /i-р хороо/	1	270,000.0	270,000.0	2023.03.10, 2023.05.25-нд тендер зарласан. 2023.06.26-нд нээлт хийх байсан бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1 дэх хэсгийн дагуу худалдан авах ажиллагааг зогсоосон.
32	120 мянгат 20, 21-р байр орчмын зам талбайн засвар шинэчлэлт. тохижилтын ажил /1-р хороо/	1	448.152.8	448.152.8	2023.03.29, 2023.05.02-нд тендер зарласан. 2023.06.02-нд нээлт хийх байсан бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1 дэх хэсгийн дагуу худалдан авах ажиллагааг зогсоосон.
33	Автобусны буудал, зам талбайн тохижилтын ажил /13, 16-р хороо/	13, 16	600,000.0	600,000.0	2023.04.12, 2023.05.25-нд тендер зарласан. 2023.06.26-нд нээлт хийх байсан бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1 дэх хэсгийн дагуу худалдан авах ажиллагааг зогсоосон.
34	Явган хүний зам талбайн засвар, шинэчлэл /11, 19-р хороо/	11, 19	552,600.0	552,600.0	2023.03.10, 2023.04.18, 2023.05.23-нд тендер зарласан. 2023.06.26-нд нээлт хийх байсан бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1 дэх хэсгийн дагуу худалдан авах ажиллагааг зогсоосон.
35	Нийтийн зориулалттай срои сууцны дулаалга фасад засвар /нисэхийн бус/	Нисэхийн бус	2,800,000.0	1,800,000.0	З аж ахуй нэгж материал ирүүлсэн. 2023.05.19 татгалзах мэдэгдэл хүргүүлсэн
36	Зам цэвэрлэгээний тусгай зориулалтын авто машин худалдан авах	-	1,050,000.0	1,050,000.0	1 дэх зарлалт 1 ч аж ахуй нэгж материал ирүүлээгүй. 2 дахь зарлалт 1 аж ахуй нэгж материал ирүүлсэн. 2023.05.10 татгалзах мэдэгдэл хүргүүлсэн
37	Крантай авто машин худалдан авах	-	150,000.0	150,000.0	1 дэх зарлалт 1 ч аж ахуй нэгж материал ирүүлээгүй. 2 дахь зарлалт 2 аж ахуй нэгж материал ирүүлсэн. 2023.05.18 татгалзах мэдэгдэл хүргүүлсэн
38	Явган хүний зам талбайн засвар, шинэчлэл /20-р хороо/	20	394,000.0	394,000.0	2023.03.10, 2023.04.18-нд тендер зарласан. 2023.05.29-нд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн. Гүйцэтгэгч компани гэрээ байгуулахаас татгалзсан.
39	Камерын хяналтын нэгдсэн төв, камержуулалтын ажил	-	1,000,000.0	1,000,000.0	2023.04.14-нд тендер зарласан. 2023.05.24-нд татгалзах мэдэгдэл хүргүүлсэн.

Бусад /1/

40	Зураг төсөв /Магадалшгүй ажил/	-	150,000.0	150,000.0	Дүүргийн Засаг даргын А/71 захирамжаар задарсан
Хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн /1/					
41	Наадамчдын авто замд явган хүний нүхэн гарц барих	-	3,900,000.0	1,235,000.0	
Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан					
1	Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг	-	1,000 0	1,000 0	2023.04.12-нд тендер зарлаж, 2023.05.12-нд нээлт хийсэн. Гүйцэтгэгч шалгараагүй байна.
2	Явган зам тавих, тохижилт хийх	1, 3, 15, 19, 20	473.6	473.6	2023.04.16-нд тендер зарлаж, 2023.05.16-нд нээлт хийсэн. Гүйцэтгэгч шалгараагүй байна.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын явцын график



1.5 Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;

2023 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн Засаг даргын 22 захирамжийн 33 заалт, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 5 хуралдааны тэмдэглэлийн холбогдох 7 заалтын биелэлтийг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэж байна.

ЗАХИРАМЖ, АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АЖЛЫН ЧИГЛЭПЭЭР:

Нийслэлийн Засаг даргын А/461 дугаар захирамжаар батлагдсан хороодын албан хаагчдыг чадавхжуулах, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх зорилгоор “Шилдэг хороо-Хэсгийн ахлагч нарын шилдэг баг” шалгаруулах болзолт уралдааныг уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд “Шилдэг хороо-Хэсгийн ахлагч нарын шилдэг баг” шалгаруулах болзолт уралдаан 2023 онд 2 че шаттай зохион байгуулагдах бөгөөд нэгдүгээр шатны ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/46 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийслэлийн 8 дүүргийн 34 хороогоор зөвлөн туслах, харилцан мэргэжил арга зүйн туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулсан.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд хяналт тавих ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/90, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/53 дугаар захирамжийн хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн түгээмэл тархацтай ашигт малтмалын тээвэрлэлтэд хяналт тавьж, 2023 оны эхний хагас жилийн

байдлаар давхардсан тоогоор 7263 тээврийн хэрэгсэл шалгаж, зөрчил гаргасан 5137 тээврийн хэрэгслийн жолоочид 130,990,000 төгрөгийн тorgууль ноогдуулж, зөрчил арилгах арга хэмжээ авч ажилласан.

Зураг. Түгээмэл тархацтай ашигт малтмал тээвэрлэлтэд хяналт тавьсан байдал



Дүүргийн Засаг даргын 2023 оны А/151 дүгээр захирамжийн дагуу 11 байгууллагын 158 тээврийн хэрэгслийн хариуцагчтай “Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ”-г байгуулан ажиллаж байна.

Дүүргийн 12, 13 дугаар хорооны иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу тус хороодод үйл ажиллагаа эрхэлдэг түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтыг 8 удаа зохион байгуулж, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан “Очир шүр” ХХК, “Баян сүмбэр бодг” ХХК, “Батадар” ХХК гэсэн 3 аж ахуйн нэгжийн олборлолтын ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан бөгөөд 17 аж ахуйн нэгж, байгууллагад батлагдсан удирдамжийн дагуу Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Газар зохион байгуулалтын алба, харьяа хороодын Засаг дарга нартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 26-ны өдрийн хооронд хяналт, шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгэн ажиллаж байна.

Дүүргийн хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын чиглэлээр: Дүүргийн мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах, цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг шуурхай авч хэрэгжүүлэх өвс, тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд 14 заалт бүхий “Бэлтгэл ажил хангуулах ажлын төлөвлөгөө”-г батлуулсан.

Мал аж ахуйн салбарт үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг даван түүлах сэрилгээр дүүргийн Засаг даргын Тамгын газрын батлагдсан төсөөт өвс 40.5тн, тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлсэн. 30 тн худалдан авахаар суулгуулан өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлсэн.

Дүүргийн Засаг даргын 2023 оны “Малчин, мал бүхий иргэдэд дэмжлэг үзүүлэх тухай” А/50 дугаар захирамжаар мал бүхий 12, 13, 14 дүгээр хорооны 336 өрхөд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.



Биеийн тамир, спортын чиглэлээр: Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/437 дугаар захирамжийн дагуу "Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтийн арга хэмжээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын 1895 ажилтан, албан хаагч, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж, ахуйн нэгж сурагчид, 25 хорооны 1999 иргэн, нийт 6800 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон. "Улаанбаатар марафон 2023" өдөрлөгийн арга хэмжээг Улсын драмын эрдмийн театрын урд талбайд 11:00-18:00 цагийн хооронд зохион байгуулж, батлагдсан хөтөлбөрийн дагуу өдөрлөгт оролцогч иргэдэд зориулсан соёл урлагийн арга хэмжээ болон спортын 4 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулж ажилласан.



1.6 Нийслэл, дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт;

❖ Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 14 удаа зохион байгуулагдан нийт 135 үүрэг даалгавар өгөгдөж, 86.7%-тай хэрэгжсэн. Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн батлуулж, хугацаанд нь тайлагнан ажилласан.

❖ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам"-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацаа зорилтууд түвшинд хүртэхээр зорин ажилласан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, албадад 2023 оны эхний хагас жилийн байдлаар 2269 өргөдөл, гомдол ирснээс 2147 хугацаандаа шийдвэрлэгдэж, 8 хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн, 114 судлагдаж байна. Үүнд;

- Бичижээр – 952
- 1800-1200 – 124
- 11-11 – 1084
- Хороо бүртгэсэн – 59
- Цахимаар – 16
- Дижитал сити – 33
- Тусгай дугаар – 1

Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газарт 314 өргөдөл, гомдол ирснээс 282 хугацаандаа шийдвэрлэгдэж, 32 судлагдаж байна. Үүнд;

- Цаасаар – 73
- 1800-1200 – 46
- 11-11- 175
- Дижитал сити – 13
- Цахимаар – 7.

**“ОНЛАЙН БИЗНЕС ТӨВ” ИРГЭН АЖ АХҮЙН НЭГЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
БҮРТГЭЛИЙН СИСТЕМД ИРСЭН ХҮСЭЛТ, ШИЙДВЭРЛЭЛТ**



1.7 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн;

- Богдын музейн цэцэрлэгт хүрээлэн, 120 мянгатын шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэнд утасгүй интернетийн сүлжээг бүрэн суурилуулсан бөгөөд Засаг даргын Тамгын газар болон 25 хорооны интернет сүлжээ, түүнд суурилсан дагалдах үйлчилгээнүүд, компьютерүүдийн ашиглалт, тохируулга, хэвийн найдвартай ажиллагаа Вэб сервер, Kaspersky серверүүдийн байнгын найдвартай хэвийн ажиллагаанд өдөр бүр хяналт тавин ажилласан. Засаг даргын Тамгын газар болон 25 хорооны “Kaspersky endpoint security” вирусны программын хугацаа дуусч дахин 1 жилийн хугацаатай гэрээ хийж суулгасан.

Дүүргийн 14,15 дугаар хорооны Засаг дарга, 3 дугаар хорооны зохион байгуулагч, 1, 5, 18 дугаар хорооны нийгмийн ажилтан болон 10 хорооны компьютерт ssd hard, ram нэмж хурд сайжруулалтыг хийсэн.

- “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжиж буй “Дижитал сити” төслийн “Хэсгийн ахлагчийн цахим систем”-ийг хороодын хэсгийн ахлагч нарыг өдөр тутмын ажилдаа хэрэглэж хэвшүүлэх, тайлан мэдээлэл, зөрчил, өргөдөл гомдол бүртгэж оруулах аргачлал, арга зүйн зөвлөгөөгөөр хангасан.



- Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим шилжилтийн бодлого, зорилттой уялдуулан Сангийн яамны Төрийн сангийн газраас “Төрийн сангийн удирдлагын цахим систем” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагааны үр хэрэгжүүлэх, төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээ болон мэдээллийг цахим ашгийг дээшлүүлэх, төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээ болон мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэн ажлын бүтээмжийн нэмэгдүүлэх, үйл ажиллагааны хяналтыг сайжруулах зорилгын хүрээнд, төрийн нууцад хамаарахаас бусад бүх төсвийн байгууллага, төслүүд, төсвийн байгууллагын харилцагчид буюу бэлтгэн нийлүүлэгчид хооронд цахим мэдээлэл солилцох, санхүүгийн гүйлгээ хийгддэг болсон.

Төрийн сангийн төлбөр тооцоог 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн цахимжуулж, төсвийн хэрэгжилтийг түргэн шуурхай зохион байгуулан, төсөв, санхүүгийн ажилтны ажлын ачааллыг бууруулаж, зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Дүүргийн харилцагч төсөвт байгууллагуудаас Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн 7100-1112 дугаарын дуудлагыг хүлээн авч зөвлөгөө өгч ажиллаж байна. Эрхийн

бүртгэлийн сан болон payroll.gov.mn программууд дээр харилцагч төсөвт байгууллагуудад заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

1.8 Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн;

Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд холбогдох стандарт, гадна, дотор тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан. Үүнд:

Дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 200 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн гадна орчны 50м хүртэлх зам талбайн зураглалыг худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд баталгаажуулж, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж ажилласан.

Дүүргийн Засаг даргын 2023 оны А/56 дугаар захирамжаар баталсан "Хоггүй Хан-уул 2023 аян"-ыг эрчимжүүлэх ажлын хүрээнд дүүргийн ЗДТГ-ын даргын "Аян нэгдэх тухай "08/508 аяны хүрээнд аж ахуйн нэгжийг хамруулсан их цэвэрлэгээг 2023 оны 04 дүгээр сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулсан. Аянд нийт 200 гаруй аж ахуйн нэгж оролцож 15,000m² орчим талбайг цэвэрлэн, 4 автобусны буудалд хөөстэй угаалга хийж орчны өнгө үзэмжийг сайжруулсан.



ХОЁРДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ЧИГҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮР ДҮН

2.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн;

Засаг даргын Тамгын газрын "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгах саналыг хэлтэс, тасгуудаас хүлээн авч нэгтгэн 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлуулж хэрэгжилтийг хангулсан.

Гүйцэтгэлийн тайлангийн эхний хагас жилийн хэрэгжилтийн хураангуйг хүснэгтээр харуулбал:

№	БҮЛЭГ	Зорилт	Хувь	Арга хэмжээ	Хувь	ҮҮХЭС (арга хэмжээ)				
						Бүрэн хэрэгжсэн 100%	Хэрэгжих шатанд 70%	Хэрэгжилт хангалттай 30%	Хэрэгжэгүй 0%	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй
1	МУЗГУАХ	14	54	22	59.5	4	15	2	-	1
2	НЗДУАХ	18	53	25	55.4	5	9	8	1	2
3	ДЗДУАХ	35	50	56	53	6	34	10	-	3
4	ХТДХҮ	1	61	70	61	6	47	11	4	2
5	БХХТ	1	62.5	7	62:5	5	1	-	-	1
6	НИЙТ	69	53	180	58.4	69	76	21	5	9

Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт: Дүүргийн Засаг даргын 2023 оны “Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, албан тушаалын жагсалт батлах тухай” А/104 дүгээр даргын 2021 оны А/1058 захирамжид нийцүүлсэн бөгөөд албан тушаалын тодорхойлолтын харьцуулалтыг боловсруулан ЗДГГ-ын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 04/301 дугаартай албан бичгээр Төрийн албан зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Батлагдсан бүтцийн дагуу төрийн захиргааны 32 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж холбогдох хэлтсээр хянуулсан бөгөөд Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо” системээр хүсэлт илгээж Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөл дээр хяналтын шатанд явж байна.

Дүүргийн Засаг даргын 2023 оны А/20 дугаар захирамжийн хавсралтаар Дотоод аудитын албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг, 2023 оны А/237 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг, хоёрдугаар хавсралтаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг, 2023 оны А/258 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар Албан бус-насан туршийн боловсролын төвийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг, хоёрдугаар хавсралтаар Соёлын ордны даргын албан тушаалын тодорхойлолтыг тус тус батлуулсан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын албан хаагчдын төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг боловсруулан Засаг даргын Тамгын газрын даргын 2023.02.20-ны өдрийн 04/279 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн.

Саналд Засаг даргын Тамгын газрын 21, хорооны 18, дэргэдэх хэлтэс, албаны 5 албан хаагчийн, нийт 44 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгохоор тусгасан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/511 дүгээр захирамжаар дээрх төрийн захиргааны 44 албан хаагчийн зэрэг дэв, түүний нэмэгдлийг шинэчлэн олгосон.

Төрийн албаны тухай хууль, түүнийг дагалдан гарсан дүрэм журмын хэрэгжилтийн хүрээнд Засаг даргын Тамгын газар, хороо, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын суп орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг холбогдох газарт хүргүүлсэн.Үүнд:

- Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 04/280 дугаартай албан бичгээр суп орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, захиалгын дагуу нийт 20 албан тушаалын суп орон тоог нөхөх тусгай шалгалтад Засаг даргын Тамгын газрын удирдах 5, 1үйцэтийн 15 албан хаагч хамрагдаж тэнцүүн. Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлийн “Нэр дэвшүүлж, санал болгох тухай” 2023 оны 68, 69, 70, 71, 72, 73, 74, 75, 192, 193, 194, 195, 202, 353, 354, 355, 356, 357, 358, 359 дүгээр тогтоолыг үндэслэн албан хаагчдыг албан тушаалд томилон шийдвэрийг ЗДТГ-ын даргын 2023 оны 04/335, 03/584 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн.

- Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03/586, 03/742 дугаартай албан бичгээр 6 албан тушаалын суп орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсний дагуу 2023.06.15-ны өдрийн тусгай шалгалтад холбогдох албан хаагчдыг хамруулсан.

- Дүүргийн Засаг даргын 2023 оны 01/147 дугаартай албан бичгээр төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 33 албан тушаалын суп орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг хүргүүлсний дагуу тусгай шалгалтад хамрагдаж тэнцүүн иргэдийг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлийн “Нэр дэвшүүлж, санал болгох тухай” 2023 оны 405, 406, 407, 408, 409, 415, 416, 417, 418, 419, 420, 421, 422, 423, 424 дүгээр тогтоолыг үндэслэн албан тушаалд томилон шийдвэрийг дүүргийн Засаг даргын 2023 оны дугаартай албан бичгээр холбогдох газарт хүргүүлсэн.

- Дүүргийн Засаг даргын 2023 оны 01/151 дугаартай албан бичгээр төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 2 албан тушаалын суп орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлд хүргүүлсэн бөгөөд тусгай шалгалтын тов зарлагдаагүй байна.

Тайлант хугацаанд нийт 5 удаагийн сонгон шалгаруулалтын захиалга хүргүүлсний дагуу тусгай шалгалтад хамрагдаж тэнцсэн 35 иргэнийг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн томилсон

Захиргааны актын эрх зүйн үндэслэлийт хянан, биелэлтийт тооцох чиглэлээр: Дүүргийн Засаг даргын 400 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 235 тушаалын эрх зүйн үндэслэлийг хууль, тогтоомжид нийцүүлэн хянан зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Засаг даргын 172 захирамжийн биелэлт 90.7% буюу хангалттай хэрэгжиж байна.

Гэрээний эрх зүйн үндэслэлийг хянах, бүртгэлжүүлэх чиглэлээр: Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албанаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 389 гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, бүртгэлжүүлсэн.

№	Гэрээний индекс	Хэлтэс	Тоо
1	4/01	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	208
2	5/01	Санхүү, төрийн сангийн хэлтэс	5
3	6/01	Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	5
4	9/01	Нийгмийн хөгжлийн хэлтэс	69
5	12/01	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	19
6	10/01	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	25
7	13/01	Цэргийн штаб	16
8	3/01	Хууль, эрх зүйн хэлтэс, Архивын хэлтэс	6
9	XO	Хөрөнгө оруулалт	36
10	НИЙТ		389

Шүүхэд төлөөлөх, хууль хяналтын байгууллагатай харилцах чиглэлээр: Захиргааны хэргийн шүүхэд 12, иргэний хэргийн шүүхэд 1, цагдаагийн байгууллагад 1 нийт 14 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлийн үндсэн дээр оролцож байна. Үүнээс анхан шатны шүүхийн 12, давж заалдах шатны шүүхийн 3 нийт 15 хуралдаанд цахимаар болон танхимаар оролцож, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 2 байна.

Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр: Хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг тайлбарлах, эрх зүйн сургалтыг иргэд, албан хаагчдад зохион байгуулах, иргэдэд хуулиин чиглэлээр лавлагаа, зөвлөгөө өгөх ажлын хүрээнд эрх зүйн сургалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 300 иргэн, албан хаагчийг хамруулж, 100 ширхэг гарын авлагыг тараасан.

Эрүүл мэндийн чиглэлээр: Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчинеөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо" 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна. 0-5, 6-17 настны иргэд өрхийн эрүүл мэндийн төвд, 18-30, 31-45, 46-60, 61-ээс дээш настны иргэд Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, "Гэгээн ар үр" эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ, оношилгоонд хамрагдаж байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар 0-5 настны 15783, 6-17 настны 33911, 18-30 настны 6091, 31-45 настны 14860, 46-60 настны 13182, 61-ээс дээш настны 8714, нийт 92541 иргэн буюу 44,2% эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ оношилгоонд хамрагдаад байна.



Сүрьеэгийн эрсдэлт бүлгийн иргэдийн дунд сүрьеэз өвчнийг илрүүлэх үзлэг шинжилгээг Монголын Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо, дүүргийн сүрьеэгийн диспансер, хороод, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулсан. Сүрьеэгийн өвчнийг эрт илрүүлэх үзлэг шинжилгээг 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 7 дугаар сарын 06-ны өдрийн хооронд иргэдийг хамруулах хуваарьт үзлэгийн дагуу 4, 5, 6, 7, 8, 9, 10, 16, 21, 23, 24, 25 дугаар хорооны эрсдэлт бүлгийн 1205 иргэнийг үзлэгт хамруулсан.




Халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд дүүргийн хэмжээнд 126176 иргэн, хамрагдахаас 26859 иргэн буюу 18.7% хамрагдсан. Үүнээс эрэгтэй 9381, эмэгтэй 17478 иргэн, шинээр оношлогдсон 112, давтан үзлэгт 6116 иргэн үзлэг, оношилгоонд хамрагдсан байна. Дараалт ихсэх өвчин, чихрийн шижин, хэв шинж-2, эрт илрүүлэгт үзлэгт 25234 иргэн буюу 17.5% Үүнээс эрэгтэй 8887, эмэгтэй 16347 шинээр оношлогдсон 6, давтан үзлэгт 2300 иргэн хамрагдсан. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд 14301 нөхөн үржихүйн насны хамрагдсан. Боловсролын үзлэгт 2536 эмэгтэй буюу 18% нь хамрагдсан байна. Хөхний үзлэг эмэгтэйчүүд хамрагдахаас 58138 хүн хамрагдахаас 18961 хүн буюу 33% хамралттай байна. оношилгоонд хамрагдвал зохих 58138 хүн хамрагдахаас 18961 хүн буюу 33% хамралттай байна.

“Хүүхдийн өвчний цогц менежмент” сургалтад эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээ үзүүлж байгаа Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн залуу 23 эмч, Сүрьеэгийн тусlamж үйлчилгээг сайжруулах, эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх, мэдлэг арга зүйгээр хангах сургалтад Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 40 эмч, “Эрүүл Монгол хүн” санаачилгын хүрээнд Хан-Уул дүүргийн 6 настай хүүхдүүдийн бие бялдрын хөгжлийн үнэлгээ ба зүрхний эмгэгийн илрүүлэх сургалтад өрхийн эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургуулиудын 39 эмчийг хамруулсан.



“Үе тэнгийн сургагч багш бэлтгэх” сургалтыг 2023 оны 5 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллежийн 28 оюутан, сурагчдыг хамруулсан.

Ерөнхий боловсролын 9 сургуулийн 7-16 насны 10532, 18 цэцэрлэгийн 2-6 насны 1182 хүүхдүүдэд амны хөндийн үзлэг, оношилгоог хийж 131 хүүхдэд шүд цоорлоос урьдчилан сэргийлэх зорилгоор форт түрхлэгийг түрхэж багш, эцэг эх, асран хамгаалагч нарт амны хөндийн эрүүл мэнд, шүдээ хэрхэн угаах сургалтыг зохион байгуулсан.



2023 оны эхний хагас жилд Дотор судлал, БЗДХ/ХДХВДОХ, андорлоги, статистик, зүрх судас, био анагаах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ зэрэг 7 чиглэлээр нарийн мэргэжлийн, төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх урт хугацааны сургалтад 10 эмч, гадаадын сургалтад 2 эмч, богино хугацааны чадавхжуулах сургалтад 157 эмч тус тус хамрагдсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр: "Мөнгөн Хан-Уул" өвлийн өвлийн тамир спортын арга хэмжээг дүүргийн аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус 79 байгууллагын нийт 1153 иргэд, албан хаагчид, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмын 4 төрөлд 53 тамирчин алтан медаль 4, мөнгөн медаль 5, хүрэл медаль 2, Монголын Бүх ард түмний өвлийн спортын XVI медаль 6, өсвөрийн шигшээ багийн тамирчид улсын хэмжээнд спортын 11 төрлөөр 24 удаагийн медаль 6, өсвөрийн шигшээ багийн тамирчин алтан медаль 73, мөнгөн медаль 43 хүрэл медаль 74 тэмцээнд нийт 531 тамирчин оролцож алтан медаль 1, хүрэл медаль 1, ОХУ-ын Красноярска цомын тэмцээнд 4 тамирчин оролцож алтан медаль 1, хүрэл медаль 1, ОХУ-ын Красноярска хотноо зохион байгуулагдсан "Красноярская лига" жудо бөхийн олон улсын тэмцээнд 11 тамирчин оролцож алтан медаль 4, мөнгөн медаль 1, хүрэл медаль 4 хүртсэн .



2023 оны 6 дугаар сарын 19-29-ний өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдаж буй Монголын Хүүхдийн спортын зуны VII Их наадамд Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 205 тамирчин спортын 18 төрөлд оролцож байна.

Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит Нисэх, алс, яармагийн бүсийн залуучуудын сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 6 дугаар сарын 03, 17-ны өдрүүдэд "Ган спорт төв"-д зохион байгуулсан. Тэмцээнд нисэх, алс, яармагийн бүсийн 15 хорооны 32 багийн 300 гаруй тамирчид өрсөлдөж, 6, 8, 10, 16 дугаар хорооны баг тамирчид дүүргийн аварга шалгаруулах шигшээ тоглолтод оролцох эрх авсан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнийг нутгийн захиргааны байгууллагуудын дунд 2023 оны 6 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тэмцээнд Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албад нийт 27 байгууллагын 19 баг оролцсон бөгөөд давхардсан 600 гаруй албан хаагчид хамрагдсан. Байгууллагын нэгдсэн дүнгээр: I байр: Татварын тоогоор II байр: Засаг даргын Тамгын газар, III байр: Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хамтарсан баг тус тус шалгарсан.



Боловсролын чиглэлээр: Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х.Кобаяши болон Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан нар 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдөр Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж”-ийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын 60-р сургуулийн засвар” төслийн гэрээнд гарын үсэг зурлаа.



Ерөнхий боловсролын сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчдын сургалтын чанарыг сайжруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, суралцах үйл ажиллагааг дэмжих, 2022-2023 оны хичээлийн жилд элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сурагчдад дэмжлэг үзүүлэхэд зорилгоор Хан-Хичээлийн 2023 Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит матетамик, физик, химийн хичээлийн олимпиадыг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 15, 52, 75 дугаар сургуулиудад зохион байгуулсан.

Олимпиадад дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 33 сургуулийн 513 сурагчдаас, амжилттай оролцож, бусдыгаа манлайлсан шилдэг 48 сурагчдад шагналаа гардуулсан.



Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний мэдлэг дадлага олгох, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор “Замын хөдөлгөөний цагаан толгой-2023” тэмцээнийг 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан. Тэмцээнд тус дүүргийн төрийн өмчийн 19 цэцэрлэгийн 266 хүүхэд оролцсон.



Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт 2023 оны 5 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд явагдсантай холбогдуулан тус дүүргийн алсын бусийн ерөнхий боловсролын 4 сургуулийн 10 бүлгийн 1 дүгээр ангид суралцаж буй 350 сурагчид 2022-2023 оны хичээлийн жилд амжилттай суралцаж, үнэлгээний шалгалтад идэвхтэй хамрагдсанд дүүргийн Засаг даргын зүгээс баяр хүргэж, дэлхийн хүүхдийн шилмэл зохиолын түүврээс бэлэглэсэн.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн сар шинийн баярын мэндчилгээ, гарын бэлгийг тус дүүргийн 100 ба түүнээс дээш настай 8 ахmad настанд хүлээлгэн өгсөн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” ўйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ахмадаа дээдэль” дэд хөтөлбөрийн хүрээнд сар шинийн баярыг утган ахmad настнуудад хүндэтгэл үзүүлэх төслийг хэрэгжүүлж, Хан-Уул дүүргийн Засаг даргын гарын бэлгийг 5500 ахmad настанд олгосон.



Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамжаар 6, 12, 13, 14, 16 дугаар хорооны зорилтот 6 өрхөд 5 ханатай иж бүрэн гэр, Бүгд найрамдах Турк улсын байгалийн гамшигт нэрвэгдсэн иргэдэд зориулсан хандивын аянд дүүргийн Засаг дарга, иргэдээс олгох хандивын 3 гэрийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгсөн.



“Эко ахмадын сувилал” ОНӨААТУГ нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргатай 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдөр гэрээ байгуулж, ахmad настнуудад хөнгөлөлттэй үйлчлэх амралт, сувиллын эрхийг авч гэрээний дагуу 2023 оны 6 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн ахmad настнуудыг хүлээн авч эхэлсэн.

Хан-Уул дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлөөс дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны A/31 дүгээр тушаалаар өөрийн байртай 21 хорооны байрилга байгууламжийн хүртээмжийн үнэлгээ хийх ажлын хэсгийг томилон 2023 оны 4 дүгээр сарын 15-21 -ны өдрүүдэд “Түгээмэл хөгжил төв” төрийн бус байгууллагатай хамтран хороодын байранд үнэлгээ хийсэн.
- Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны A/255 дугаар захирамжаар 25 хорооны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зөвлөлийг байгуулж, “Хөгжлийн бэрхшээл ба хүний ялгаатай байдал” сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 25 хорооны 100 гаруй ажилтан, албан хаагч, иргэд оролцсон.
- Хөгжлийн бэрхшээлтэй буюу харааны бэрхшээлтэй иргэдийн дунд хонхтой бөмбөгийн тэмцээнд 70 иргэн, Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд пара бочи, тусгай бочи 2 насны ангилалд 60 хүүхэд, хараагүй насанд хүрэгчдийн дунд үндэсний бөхийн 32 бөхийн барилдаан, хөгжлийн бэрхшээлтэй буюу харааны бэрхшээлтэй иргэдийг нийслэл болон бусад дүүргүүдийн аварга шалгаруулах тэмцээн 82 иргэн, Нийслэлийн аварга шалгаруулах оюуны бэрхшээлтэй хүний спорт тусгай бочи 10, тулгуур эрхтний бэрхшээлтэй сугаа волейболын тэмцээнд 20 иргэн, “Хөл бөмбөгийн анхдугаар лиг” харааны бэрхшээлтэй хүний хөл бөмбөгийн тэмцээнд 6 иргэн, “Хөл бөмбөгийн анхдугаар лиг” харааны бэрхшээлтэй хүний хөл бөмбөгийн тэмцээнд 6



Хүүхдээ сонсох өдрийг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, хүүхдэд тулгамдаж буй асуудлыг сурагчдын өөрсдийн оролцоотойгоор сонсох, санал хүсэлтийг нэгтгэн шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилгоор 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус өмчийн 18 сургуулийн ахлах ангийн сурагчдын төлөөлөл 70 сурагч оролцсон.



Хан-Уул дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт суралцаж буй хүүхэд багачуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, соёл урлаггаар дамжуулан гоо зүйн боловсрол олгох, харилцан суралцах, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилготой Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит “Хүүхдийн урлагийн Их наадам”-ыг 2023 оны 5 дугаар сарын 15, 20, 21-ний өдрүүдэд дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан.

Хүүхдийн урлагийн Их наадамд дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 34 цэцэрлэгийн 374 хүүхэд, ерөнхий боловсролын 27 сургуулийн 638 сурагч, нийт 1000 гаруй хүүхдүүд оролцож, урлагийн 3-4 төрөлд авьяас чадвараа сорин өрсөлдсөн.

Хүүхдийн урлагийн Их наадмын цэцэрлэгийн насын ангиллын “Шилдэг багш”-аар “Үнсгэлжин ба 7 одой” цэцэрлэгийн багш В.Ухаанбилэг, “Шилдэг цэцэрлэг”-ээр 73 дугаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн “Шилдэг багш”-аар нийслэлийн ерөнхий боловсролын 18 дугаар сургуулийн багш О.Дорждэрэм, “Шилдэг сургууль”-иар нийслэлийн ерөнхий боловсролын 18 дугаар сургууль тус тус шалгарсан.



Жендерт сууринсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хугацаанд “Цагаан туутстан” хөдөлгөөн, жендерийн цахим болон танхимиын сургалтууд зохион байгуулж, 3 төрлийн видео шторк, 8 постер, 10 мэдээ мэдээллийг цахим сайт, пейж хуудсанд байршуулж, иргэд олон нийтэд сурталчилсан.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах, жендерт сууринсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Харилцан хүндэтгээ” сарын аяны хүрээнд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг нэгдэхийг уриалж, “Эмэгтэйчүүдийн манлайлал” уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулан 75 албан хаагч, Жендерийн тухай ойлголт, Жендерт сууринсан хүчирхийлэл, Хөдөлмөрийн харилцааны ялгаварлан гадуурхалт сургалтыг 6 байгууллагын 223 албан хаагчдад, “Жендерийн талаарх ойлголт, харилцаа хандлага” сургалтыг Жендерийн салбар хорооноос 8 сургуулийн 200 гаруй оюутан, сурагчдад, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллежийн оюутнуудын дунд илтгэлийн тэмцээнд 50 гаруй оюутан, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт” сэдэвт нээлттэй



хэлэлцүүлэг, Жендэрийн Үндэсний хороо, Удирдлагын академиас 'Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт' үндэсний форумд оролцохын зэрэг үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг www.khanuuil.mn, "Хан-Уул Эко дүүрэг", "Хан-Уул хүүхэд" болон хороодын албан ёсны цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчилсан.

Түргэн үйлчилгээний цэг, ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр: Наадамчдын зам, Нисэхийн зам дагуу авто болон явган хүний замыг хааж, зөвшөөрөлгүй байршуулсан 71 түргэн үйлчилгээний цэгт Газар зохион байгуулалтын албатай хамтран хугацаатай мэдэгдэл хүргүүлсэн.



Дүүргийн Засаг даргын 2023 оны "Газрын зөрчил арилгаж, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах тухай" А/202 дугаар захирамжаар зөвшөөрөлгүй байршуулсан түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулж, зөвшөөрөлгүй байршуулсан нийт 11 ТҮЦ-ийг нүүлгэж, 12 тээврийн хэрэгслийг ачуулж, газар чөлөөлсөн. Үүнд:

- 11-р хороо Туул голын зам дагуу 3 түц, 12 тээврийн хэрэгсэл;
- Наадамчдын зам, Нисэхийн зам дагуу 8 ТҮЦ;



Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны "Ил задгай, гар дээрх худалдаа үйлчилгээнд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай" удирдамжаар дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн газар, хороодтой хамтарсан ажлын хэсэг 13 удаагийн хяналт шалгалт хийж, зөрчлийг тухай бүр арилган, 3 иргэнд тус бүр 20 нэгжийн торгуулийн арга хэмжээ авч, хүнсний аюулгүй байдлыг хангулан, зөвлөн тусалж ажилласан.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны "Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт ил задгай, зөвшөөрөлгүй, худалдаа, үйлчилгээ явуулж буй иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж" удирдамжаар Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, дүүрэг дэх Цагдаагийн газар, Мал эмнэлгийн тасаг, хороодтой хамтарсан ажлын хэсэг 6 удаагийн хяналт шалгалт хийж, зөрчлийг тухай бүр арилган, 2 иргэнд тус бүр 20 нэгжийн торгуулийн арга хэмжээ авч, хүнсний аюулгүй байдлыг хангулан, зөвлөн тусалж ажилласан.



Өрхийн орлогыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх сонирхолтой иргэдийг дэмжиж улирлын чанартай түр худалдааг 2 байршилд зохион байгуулж, 36 иргэнийг дэмжиж ажилласан.

Явуулын үйлчилгээтэй хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд стандарт шаардлагын мөрдүүлэх, дэмжин ажиллах числэлээр:

- Дүүргийн нутаг дэвсгэрт Зайсан туул гол дагуу явуулын үйлчилгээтэй түргэн хоолны үйлчилгээ эрхлэгчдэд эрүүл ахуйн стандарт шаардлагад хяналт шалгалт хийж, Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран газар чөлөөлөх албан мэдэгдэл хүргүүлсэн.

- Дүүргийн Засаг даргын 2023 оны "Газрын зөрчил арилгаж, нүүргэн шилжүүлэх арга хэмжээ авах тухай" А/202 дугаар захирамжаар эрүүл ахуйн стандарт шаардлага хангахгүй, зориулалтын бус зөөврийн байгууламжид түргэн хоолны үйлчилгээ явуулж буй нийт 15 түргэн хоолны цэгийг нүүлгэн шилжүүлсэн.

Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгийн стандарт шаардлага хангаж буй 5 иргэнийг олон нийтийн арга хэмжээнд оролцуулан, үйл ажиллагааг дэмжин, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад хяналт тавин ажиллаж байна.



Айдын даваа зам дагуу зөвшөөрөлгүйгээр зориулалтын бус байгууламжид хоолны үйл ажиллагаа явуулж буй 27 иргэнд Нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтарч газрын зөрчил арилган газар чөлөөлөх албан мэдэгдэл хүргүүлэн ажилласан.



Аялал жуулчлалын чиглэлээр: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн баталсан "Зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтран аялал жуул члалын бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд таниулах арга хэмжээ зохион байгуулах тухай" ажлын удирдамж батлуулсан.

Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолбортой хамтран нийт 3 удаагийн олон нийтийн арга хэмжээ зохион байгуулж, иргэдэд сурталчлан ажилласан. Үүнд: "Бүргэдийн баяр", "Тэнгэр" олон улсын бөө мөргөлийн фестиваль", "Хамтдаа алхаад эрүүлжье" 4 удаагийн явган алхалтыг зохион байгуулж 500 гаруй иргэн хамрагдсан. Мөн "Улаанбаатар Травэл Экспо- 2023" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд амралтын газар, жуулчны баазуудыг хамруулж бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан ажилласан.



БАТЛАН ХАМГААЛАХЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нь Батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ, 2023 оны зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус мөрдлөг болгон Цэргийн штабын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 54 арга хэмжээ төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 62,5 хувийн биелэлттэй хэрэгжсэн.

Дайчилгааны бэлэн байдал, орон нутгийн хамгаалалт, төлөвлөгөөний хавсралтуудын биелэлт, зарлан мэдээлэл, тодотгол, бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын талаар:

Дайчилгааны тухай хууль, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2020 оны оч/мн 600/02 дугаар удирдамж, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, төлөвлөгөө, Нийслэлийн Хан-Уул дүүргээс Зэвсэгт хүчний анги салбарыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах болон орон нутгийн цэргийг байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөөг тус тус удирдлага болгон 2023 оны эхний хагас жилаах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлээ. Үүнд:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны мн/01 дүгээр албан даалгаврыг үндэслэн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны н/01 дүгээр захирамжаар 2023 онд ажиллах дадлагын дохиог тогтоосон. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас улирлын дохиог 1 удаа, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас дотоодын зарлан мэдээллийн дохиогоор 1 удаа Цэргийн штабын тайван цагийн бүрэлдэхүүн, Хан-Уул дүүргийн 25 хороо, дүүргийн цугларах, шилжүүлэх байруудад тус тус өгч, холбоо, зарлан мэдээллийн найдвартай ажиллагааг шалгаж, томилгоот бүрэлдэхүнд дадлага олгосон.



Нийслэлийн Засаг даргын тодотгол явуулах тухай н/04 дүгээр захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын тодотгол явуулах тухай захирамжийн төслийг боловсруулан, батлуулж, цэргийн дайчилгааны тодотголыг Улаанбаатар цэргийн хүрээний анги байгууллага болон орон нутгийн цэргийн анги байгууллагуудтай 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 27-ны өдрүүдэд явуулсан.



Нийслэлийн Засаг даргын 2023 оны н/02, н/03 дугаар захирамж, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчийн 2023 оны н/07 дугаар тушаалыг үндэслэн цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг Зэвсэгт хүчний 065 дугаар ангид 04 дүгээр сарын 24-нөөс 04 дүгээр сарын 28-ны өдөр, 314 дүгээр ангид 05 дугаар сарын 22-ноос 05 дугаар сарын 26-ны өдрийг дуустал тус тус зохион байгуулсан.



Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын ахлах болон дунд ангийн сурагчдын дунд “Монгол цэрэг” сэдэвт зохион бичлэг, гар зургийн уралдааныг 2023 оны 3 дугаар сарын 01-13-ны өдрүүдэд зохион байгуулж, төрийн өмчтэй болон хувийн хэвшлийн 21 сургуулиас нийт 164 бүтээлийг ирүүлсэн.



Зохион бичлэгийн уралдааны тэргүүн байрт 163 дугаар сургуулийн 11А ангийн сурагч Э.Амин-Эрдэнэ, дэд байрт 115 дугаар сургуулийн 126 ангийн сурагч Э.Хүслэн, гутгаар байрт 18 дугаар сургуулийн 10а ангийн сурагч Д.Яруу-алдар, Гар зургийн уралдаанд тэргүүн байрт 18 дугаар сургуулийн 7А ангийн сурагч Д.Азжаргал, дэд байрт “Оном” сургуулийн 9б ангийн сурагч Э.Эрмүүн гутгаар байрт 18 дугаар сургуулийн 10а ангийн сурагч Э.Баяржавхлан нар тус тус шалгарсан.



Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тохиолдуулан “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” нээлттэй хаалганы өдөрлөгийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Боловсролын хэлтэс, Зэвсэгт хүчний 011 дүгээр ангитай хамтран 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр ангийн байрлалд зохион байгуулсан.

Хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгын хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 10, 118 дугаар сургуулийн ахлах ангийн 70 гаруй сурагчдыг Монгол цэргийн музейг танилцуулах, үзмэр үзүүлэх ажлыг 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ой, Монгол Улс Энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны 21 жилийн ойг тохиолдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын

албан хаагчдын дунд Дартс, Скат гар бууны буудлагын тэмцээнийг 2023 оны 3 дугаар сарын 12-ны өдөр дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “147 клуб”-т зохион байгуулсан.



Дартсын төрөлд тэргүүн байрт Л.Отгонбаяр ахлагчтай Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс, дэд байрт З.Баасандорж ахлагчтай Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, гутгаар байрт Б.Ариунаа Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 9мм-ийн ПМ гар бууны төрөлд тэргүүн байрт З.Баасандорж ахлагчтай Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, дэд байрт Б.Очир ахлагчтай Хууль, эрх зүйн хэлтэс, гутгаар байрт Э.Баярбат ахлагчтай Нийгмийн хөгжлийн хэлтэс шалгарч шагналыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр гардуулсан.



Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойн төлөвлөгөөт ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын цогцолбор “Дөл” тэмцээнийг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Зэвсэгт хүчний 013 дугаар материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан.

Тэмцээний нээлтийн ажиллагаанд Хан-Уул дүүргийн Засаг Тамгын газрын дарга С.Энхбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орлогч, хурандаа Б.Эрдэнэпил, Төлөвлөлт, сургалтын офицер хошууч, Ц.Энхтайван, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Тоо бүртгэлийн ахлах офицер, дэд хурандаа Д.Баасанхүү, Зэвсэгт хүчний 013-р ангийн захирагч, хурандаа Ч.Эрдэнэболд, Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Лхагвадэмбэрэл болон сургуулиудын захирал нар оролцсон.



“Дөл” цэргэг слогтын цогцолбор тэмцээнийг 8 үзүүлэлтээр зохион байгуулж, бага минутын системээр дүгнэн 1:07 минутаар тэргүүн байрт 114 дүгээр сургуулийн “Шонхор” баг, 3:11 минутаар дэд байрт 118 дүгээр сургуулийн “Сүлд” баг, 6:33 минутаар гутгаар байрт 60 дугаар сургуулийн “Цэгц” тусгай байрт 32 дугаар сургуулийн “Офицерууд” баг тус тус эзэлсэн.



Цэргийн штабаас аж ахуйн нэгж байгууллагуудад цэргийн үүргийн биелэлтэд хяналт шинжилгээ хийсэн дүнгийн талаар:

Батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх ажлыг дүүргийн Засаг даргын баталсан удирдамжаар 2023 онд 6 байгууллагад хийхэс Худалдаа, аж үйлдвэрлэлийн танхимыг шалгахад 18-50 насны 45 цэргийн үүрэгтний нэрийн жагсаалтыг гаргаж, 100 хувь хамруулахад цэргийн алба хаасан 17, мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан 14 иргэн байлаа.

Цэргийн бүртгэлийн талаар:

Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны "Цэргийн бүртгэл явуулах тухай" А/331 дүгээр журмыг удирдлага болгон Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/598 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд 2023 оны цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлыг хэсгийг томилж, штабын офицеруудыг дүүргийн 25 хороонд хуваарилан, 2023 оны 01 дүгээр сарын 04-нөөс 20-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Цэргийн бүртгэлийг дүүргийн хүн амын тоо бүртгэлтэй нягт уялдуулан зохион байгуулж, байнгын оршин суугч, оюутнуудыг оршин суугаа хаягаар нь, дүүргийн цэргийн бүртгэлийн дүнг 2022 оны жилийн эцсийн хүн амын статистик суурин мэдээтэй харьцуулсан судалгаагаар гаргаж, Е-Монголия портал веб сайттай хамтран зохион байгуулж, 7379 иргэний хүсэлтийг баталгаажуулж дүүргийн хэмжээнд цэргийн бүртгэлийг 95,3 хувьтай зохион байгуулсан.



Цэрэг халалт, таталт, цэргийн гэрээт албанад элсүүлэх, эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эрүүлжүүлэх ажлын талаар:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/371 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын А/203 дугаар захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/45 дугаар тушаалаар ажлын төлөвлөгөө, ажиллах 140 албан тушаалтаныг томилон баталгаажуулж хэрэгжилтийг ханган ажилласан.

2023 нэgdүгээр ээлжийн цэрэг татлагыг 05 дугаар сарын 05-наас 07-ны өдрийг дуустал хугацаанд дүүргийн Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байранд зохион байгуулсан. Зэвсэгт хүчиний жанжин штабаас өгсөн тоо даалгаврыг 100 хувь биелүүлсэн.



Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.17 дахь заалтыг үндэслэн 2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаас хоцорсон 128 иргэнд мэдэгдэх хуудас хүргүүлэн 2023 оны 05 дугаар сарын 17-ноос 22-ны өдрүүдэд хүлээн авч, асуудлыг шийдвэрлэн хүндэтгэн үзэх шалтгаангүй 89 иргэнд торгууль оногдуулж, 13,350,000 (арван гурван сая гурван зуун тавин мянга) төгрөгийг Хан-Уул дүүргийн 1 өрийн сангийн татварын алдангийн дансанд төвлөрүүлсэн.

“Оюутан-цэрэг сургалт”-ын талаар:

Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/376 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2023 оны А/145 дугаар захирамжийн дагуу “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутны бүртгэлийг 2023 оны 03 дугаар сарын 01-ний 28-ны өдрүүдэд үндэсний портал сайт “E-Mongolia”-р бүртгэлийг хүлээн авч, дүүргийн хэмжээнд 9 их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн шаардлага хангасан 185 оюутан, суралцагчид бүртгэж, эрүүл мэндийн үзлэг болон бие бялдарын шалгалтад тэнцсэн 145 иргэнийг онолын сургалтад хамруулж байна.



Цэргийн дүйцүүлэх албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан байдал

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа байдал:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 44 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/469 дүгээр захирамжийг үндэслэн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/295 дугаар захирамжаар цэргийн дүйцүүлэх албанад 6 иргэнийг элсүүлсэн.



Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж байгаа байдал:

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 119 дүгээр тогтоолыг үндэслэн 2023 онд цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 1994-1997 оны 1560 иргэнд мэдэгдэх хуудсыг хүргүүлж, 2023 оны 05 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд мөнгөн мөнгөн төлбөр тогтоох ажлыг зохион байгуулж, 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 156 иргэнд мөнгөн төлбөр тогтоож, Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 51 иргэнээр 56,817,629 (тавин зургаан сая найман зуун арван долоон мянга зургаан зуун хорин ес) төгрөгийг төвлөрүүлэн хуулийн дагуу 25 иргэнийг мөнгөн төлбөрөөс чөлөөлж тэмдэглэл хөтөлсөн.

Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалт, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:

Төрийн албаны тухай хуулийн дагуу ажилтны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, нууцын хадгалалт, хамгаалалт, нууцын горимыг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Төрийн болон албаны нууцын тухай хууль, цэргийн бүртгэлийн үеийн мэдээллийн аюулгүй байдлыг хangan ажиллах чиглэлээр цэргийн бүртгэлийн нэгдсэн семинарыг 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж, дүүргийн 25 хорооны Засаг дарга, зохион байгуулагч нарт танилцуулга хийн зөвлөмж өгч, төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа /маягт №2/-г бэлтгэж, нийт 50 албан тушаалтнаар нууцын баталгаа гаргуулсан.



Тус дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цэргийн штабаас 2022 онд төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн н/17 дугаартай албан бичгээр Тагнуулын ерөнхий газрын Төрийн нууцын хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Зэвсэгт хүчний мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмын хавсралтаар батлагдсан бүртгэлүүдийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар хөтлөлтийг хийсэн.


Цэргийн штабын мэдээлэл боловсруулдаг компьютерүүдэд Мэдээллийн технологи, цахим сан хариуцсан мэргэжилтнээр албан ёсны эрхтэй вирусны программыг суулгуулж бүртгэлийг /маягт №19/ хөтөлсөн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас чиглэл ирүүлсний дагуу Цэргийн штабын тэмдэг, нууцын тэмдгүүд, лацны тэмдэг, техник хэрэгслийн дотоодын үзлэгийг 2023 оны 04 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд зохион байгуулж, үзлэг явуулсан тухай н/29 дугаартай илтгэх хуудсыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлсэн.

2.2 Төсвийн орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөөт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, нийслэлийн төсвөөс дүүргийн төсөөт олгож буй санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;

Дүүргийн төсвийн орлогын талаар: 2023 оны эхний эхний хагас жилийн байдлаар 121,109.5 сая төгрөг орох төлөвлөгөөтэйгээс 131,819.0 сая төгрөгийн орлого бүрдэж, 108.8 хувийн биелэлттэй байна.

Chart Title



Дүүргийн 2023 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг нийт 13-н дансны 1-5 дугаар сарын орлого болон зарлагын гүйлгээгээр тулган хянаж, Татварын хэлтсийн орлогын эдийн засагчтай тооцоо нийлэн Дүүргийн Нэгдсэн Санхүүгийн тайланд амжилттай нэгтгэгдлээ.

Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, улс, нийслэл, орон нутгийн төсвийн брэлгүүтийн жилийн эхнээс жиуд ханцан биелүүлжэх тухай дүүргийн Засаг дарын 2023 оны A/21 дүгээр захирамжийг батлуулж холбогдох хэлтсүүдэд хүргүүлэн хамтран ажилласан. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж орлогын давалт, тасралтын мэдээллийг 7 хоног бүр, захирамжийн биелэлтийг улирал бүр хүлээн авч нэгтгэн удирдлагад танилцуулан ажиллаж байна.

Нийслэлд төвлөрүүлэх орлогын талаар: Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хяналж холбогдох запруулах бичилтийг хийн баталгаажуулсан. Дүүргийн ерөнхий орлогын дансанд татварын нэр төрлөөр 131,888,1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, Нийслэлд 87,517.8 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэв.

Улсын Тэмдэгтийн хураамж буцаан олгох талаар: Орон нутгийн төсвийн орлогын биелэлтийг сар бүр Татварын хэлтсийн орлогын эдийн засагчтай замд явваа татварын орлого болон татварын нэр төрлийн буцаасан гүйлгээг тулган баталгаажуулж, тооцоо нийлэн сарын биелэлтийг дүгнэн ажилласан.

Төсвийн “тэг” үлдэгдэлтэй данснаас 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 167 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын татварын нэр төрлийн орлогын буцаах болон запруулах гүйлгээнд 477,351.4 мянян төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.

Татварын хэлтсээс ирүүлсэн албан бичиг, жагсаалтыг улсын тэмдэгтийн хураамжийн 100200100941 тоот дансны хуулга, шүүхийн захирамж, иргэн, аж ахуйн нэгжийн өргөдөл, иргэний үнэмлэх, гэрчилгээний хуулбар, мөнгө тушаасан баримт, татварын тодорхойлолт зэргийг нарийвчлан тулгаж, төлбөрийн хүсэлт бичиж батлуулан орлого бууруулах гүйлгээ хийв.

2.3 Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал;

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх 3 бүлэг 41 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, хэрэгжүүлсэн өөгөөд эхний хагас жилийн биелэлт нэгтгэгдэж байна.

Дүүргийн төр захиргааны байгууллагудын үйл ажиллагаа, хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 5 зөвлөмж гарган Засаг даргын Тамгын газрын 2023 оны 06/82, 06/382-388, 06/571 тоот албан бичгүүдээр давхардсан тоогоор 59 байгууллагад хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллаж байна. Тухайлбал; Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 1 дүгээр улиралд дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй нийт 18 тогтоол, шийдвэрийн 30 заалтын

хэрэгжилтэд, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд 56 хувь, "Хэрэгжих шатанд" гэж үнэлэгдсэн. Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын 2023/04 дүгээр зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06/571 дүгээр албан бичгээр дэргэдэх 24 байгууллагад хүргүүлсэн.

Мөн дүүргийн Засаг даргын 2023 оны хариуцлагын гэрээний 2 үүлэг 43 зорилт, 73 арга хэмжээний 1 улирлын хэрэгжилт 36% Засаг даргын Тамгын газрын 2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн тайлангийн 5 бүлэг, 68 зорилт, 180 арга хэмжээний хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс тус бүрээр нэгтгэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 47.8%, тус тус "Эрчимжүүлэх шаардлагатай" байна.

**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ 1 ДҮГЭЭР
УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ**



**ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН
2023 ОНЫ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**

№	Бүлгийн нэр	Зорилт, арга		Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй /100/	Тодорхой үр дундаж хүрсэн /70-100/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/	Үр дунгуй /0-30/	Үнэлэх боломжтүй	Үнэлгээ /хувь/
		Хэмжээ, үр дундаж	Зорилт, арга								
1	Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг	38	68	1	5	56	4	2	34.6		
2	Нийслэлийн Засаг даргын дунд, богино хугацааны бодлогын баримт хэрэгжилт	5	5		1	2	1	1	1	37.5	

НИЙТ ДҮН	43	73	1	6	58	5	3	36
----------	----	----	---	---	----	---	---	----

Төсвийн тухай хуулийн 54.2-т “ТӨЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, төсөл, сан, төрийн болон орон нутгийн өмчт аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн тайланд хамруулна” гэж заасны дагуу Засгийн Газрын санхүүгийн нэгтгэлийн ЭТАЙЛАН системд Дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагддаг төсөвт 87 байгууллагын 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт, касс харилцахын нэгтгэл, нэмэлт санхүүжилтийн тооцоог тулган Сангийн Яамны нэгтгэлийн Этаильанд байгууллага бүрээр тулган шалгаж хүлээн авч дүүргийн нэгдсэн тайланд Нийслэл дэх төрийн Аудитын газраар шалгуулж стандарт дүгнэгдэв.

2.4 Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал:

Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах хүрээнд албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх “Үнэлгээний баатарын бүрэлдэхүүнийг ЗДТГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/55 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Засаг даргын Тамгын газрын 10 хэлтэс, албадын 13-45, ТҮ-20, хороодын Зохион байгуулагч-26, нийгмийн ажилтан-13, нийт 104 албан хаагчийн 2023 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн нэгжийн даргын үнэлгээг, тайлангийн хамт 06 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авч, 16-ны өдөр хуралдан, үнэлгээг бодитой дүгнэсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч баталгаажуулсан, холбогдох урамшууллыг Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын -ны өдрийн Б/ 181 дүгээр тушаалаар олгосон.

Үнэлгээний баатарын бүрэлдэхүүнийг ЗДТГ-ын даргын 2023 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн нэгжийн даргын үнэлгээг, тайлангийн хамт 06 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авч, 16-ны өдөр хуралдан, үнэлгээг бодитой дүгнэсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч баталгаажуулсан, холбогдох урамшууллыг Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын -ны өдрийн Б/ 181 дүгээр тушаалаар олгосон.

Үнэлгээний баатарын бүрэлдэхүүнийг ЗДТГ-ын даргын 2023 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн нэгжийн даргын үнэлгээг, тайлангийн хамт 06 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авч, 16-ны өдөр хуралдан, үнэлгээг бодитой дүгнэсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч баталгаажуулсан, холбогдох урамшууллыг Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын -ны өдрийн Б/ 181 дүгээр тушаалаар олгосон.

Төрийн захиргааны албан хаагчдыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу үнэлсэн. Үүнд:

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт /70 оноо/
2. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт /15 оноо/
3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ /нэгжийн даргын үнэлгээ/ 10 оноо
4. Хандлага ёс зүй, ур чадварын үнэлгээ /хамт олны үнэлгээ/ 5 оноо
5. Нэгжийн даргын нийт оноо /100 хүртэл/

Төрийн үйлчилгээний албан хаагчдыг Засаг даргын Тамгын газрын Дотоод журмын 11 дүгээр заалтад тусгагдсан шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгсөн. Үүнд:

1. Ажлын цаг ашиглалт /5 бал/
2. Багаар ажиллах ур чадвар ажлын хариуцлага / 10 балл/
3. Ёс зүй, харилцаа /5 балл/
4. Үндсэн үүрэг ажлын гүйцэтгэл /40 балл/
5. Үүрэг даалгаврын биелэлт /20 балл/
6. Техникийн бүрэн бүтэн байдал /20 балл/
7. Нийт 100 хүртэлх оноогоор.

Дээрх шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийг баримтлан үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний саналыг Төсвийг шууд захирагчид хүргүүлж, албан хаагчдаас

гарсан алдаа дутагдлыг арилгах, чадавхыг дээшлүүлэх арга хэмжээг дараагийн тайлант хугацааны төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг боловсруулан хэлтэс, алба, хороодод хүргүүлсэн. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолд заасан хугацаанд тайлангаа хүргүүлж байх;
- Гүйцэтгэлийн тайлан иж бүрэн үг, үсэг найруулгын алдаагүй, бичмэл тайлан шиг дэлгэрэнгүй тайлбарлаж тоочих хэлбэрээр бус, бодит баримттай судалгаанд тулгуурлан тоон дүн мэдээллийг нэгтгэн товч, тодорхой тусгаж, 1000 тэмдэгтэд багтаан тайлагнах;
- Төсөв тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа төсвийн зарцуулалтын талаар дүн мэдээг заавал тусгах, мөнгөний нэгжийн орныг зөв бичих;
- Төсөв тусгаагүй ч тодорхой санхүүжилт гарсан л бол гүйцэтгэлийн талаар товч мэдээлж, эх үүсвэрийг тусгах;
- Төлөвлөлтийн уялдаа хэсэгт аль болох бодлогын баримт бичгийн холбогдох заалтыг тусгах;
- Зорилт арга хэмжээтэйгээ уялдуулж шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингээ бодитой зөв тооцож тусгаж тайлагнах;
- Үсгийн фонд болон үсгийн хэмжээг нэг стандарт хэмжээнд оруулах;
- Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тайлагнахдаа он сар өдөр, хувь болон тоон үзүүлэлттэй бүрэн тайлагнах;
- Товчилсон үгийг аль болох бага хэрэглэх.

2.5 Үндсэн чиг үүргийн биелэлт, үрд дунд дотоод аудит, хяналт эсвэл шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх, уг ажлын дүгнэлтийг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлсэн байдал;

Төрийн өмчт 31 цэцэрлэг, 23 сургуулиудын тогтмол зардал, урсгал засварын зардал төлөвлөлт, төсвийн гүйцэтгэлд сар бүр хяналт тавин, шинэчлэгдэн гарч буй Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдийг тухай бүрт танилцуулан, холбогдох заавар зөвлөгөөг өгч ажилласан.

“Дүүргийн 2022 оны жилийн сэцийн санхүүгийн тайланц хийсэн аудитын шалгалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу Нийслэл дэх Төрийн аудитын шалгалтаар зөрчилгүй гарсан, зөрчлийг аудитын явцад залруулсан байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч, эд хариуцагч нарт үндсэн цалингийн 1-2 сараар бодож урамшуулал олгох, зөвлөмж, акт албан шаардлага авсан төсвийн шууд захирагч, санхүүгийн ажилтнуудад хариуцлагын арга хэмжээ авч ажиллалаа.

2.6 Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал

Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны чиглэлээр:

2023 оны эхний хагас жилийн байдлаар Хан-Уул дүүргийн хэмжээнд 20612 бичиг ирж шийдвэрлэлтийн хувь 98,26%, шийдвэрлэлтийн дундаж хоног 6,61 байсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар 17952 бичиг ирж шийдвэрлэлтийн хувь 97,91% хувь шийдвэрлэлтийн дундаж хоног 6,02 байна. Тайлант хугацаанд 9273 албан бичгийг төлөвлөн холбогдох газарт дундаж хоног тутамд гаргаж Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулж ажилладаг бөгөөд тайлант хугацаанд нийт 8 мэдээг бэлтгэн танилцуулсан байна. Мөн дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж дээд шатны байгууллагад танилцуулан ажилладаг бөгөөд тус ажлын хүрээнд сар тутмын 6, улирал тутмын 2 мэдээг тус тус гаргаж Нийслэлийн Архивын газарт хүргүүлсэн.

Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газар нь нийт 2348 албан бичгийг цахим болон цаасан хэлбэрээр хүлээж авсан бол 2023 оны эхний хагас жилд 2004 бичиг хүлээн авсан буюу


энэ хугацаанд ирсэн бичгийн тоо 344-өөр өссөн байна. Нийт албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 2023 оны эхний хагас жилийн байдлаар 95,56%, шийдвэрлэлтийн дундаж хоног 6.43 байсан бол 2023 оны эхний хагас жилд 96,13% шийдвэрлэлтийн дундаж хоног 5.78 байна.

Графикаар харуулбал:



Хариутай бичгийн тоо 2023 оны эхний хагас жилийн байдлаар 167 байсан бол 2023 оны эхний хагас жилд 203 буюу 36 хариутай албан бичгээр өссөн бөгөөд хаалтын хувь нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар 95,56%, харин 2023 оны эхний хагас жилд 96,13% байна. Зөрчлийн тоо 2022 оны эхний хагас жилийн байдлаар 50 байсан бол 2023 оны эхний хагас жилд 8 буюу 42-оор буурсан байна.

❖ Нийслэлийн Архивын Газрын даргын 2018 оны А/05 дугаар тушаалаар дүүргийн төр захиргааны байгууллагуудын баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих эрхийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт албан ёсоор шилжүүлсэнтэй холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн ирсэн бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажилласан мэдээг сар тус бүрээр графикт харуулав.



Тус ажлын хүрээнд тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд нийт есслен дүнгээр 9563 албан албан бичгийн шийдвэрлэлтийг хянаж үүнээс 9370 албан бичгийн шийдвэрлэлтийг хангалттай гэж үзэн баталгаажуулж, 183 албан бичгийн шийдвэрлэлтийг хангалтгүй гэж үзэн цуцалсан байна.

Байгууллагын албан бичигт стандартт хангуулах чиглэлээр:

Хан-Уул дүүргийн Засаг даргын А захирамж 2023 оны эхний хагас жилийн байдлаар 1119, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 739, нийт 1858 захирамжлалын бланк хэвлэгдсэн бөгөөд зохион байгуулалт, мэдээлэл, лавлагааны 3604 баримт бичигт Монгол Улсын MNS 5140:2021 стандартыг мөрдлөг болгон хяналт тавьж ажилласан.

Захирамжлалын баримт бичгийн хэвлэмэл хуудасны мэдээ:

№	Төрөл	2023.05 сар
1	Засаг даргын захирамж	1119
2	Засаг даргын Тамгын газрын даргын тушаал	739
3	Нийт	1858

Зохион байгуулалтын баримт бичгийн хэвлэмэл хуудасны мэдээ:

№	Хэвлэмэл хуудасны төрөл	Нийт зарцуулсан хэвлэмэл хуудасны тоо	Хүчингүй болгосон хэвлэмэл хуудасны тоо
1	Засаг даргын A4	106	21
2	Засаг даргын A5	310	19
3	Засаг даргын гадаад	-	-
4	Тамгын газар A4	201	15
5	Тамгын газар A5	1129	63
6	Тамгын газар гадаад	-	-
7	НИЙТ	1746	118

Захирамж, тушаалын саналын хуудас олгосон мэдээ:

Д/Д	Төрөл	2023.05 сар
1	Засаг даргын А захирамжийн саналын хуудас	349
2	ЗДТГ-ын даргын А тушаалын саналын хуудас	55
3	Засаг даргын Б захирамжийн саналын хуудас	80
4	ЗДТГ-ын даргын Б тушаалын саналын хуудас	191
5	Дээд газраас ирсэн тогтоол, захирамж, тушаал, хурлын тэмдэглэлийн саналын хуудас	6
6	НИЙТ	681

Засаг даргын Тамгын газрын 2023 онд хөтлөгдөх "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг 188 хэрэгтэйгээр шинэчлэн боловсруулж, байгууллагын Баримт нягтлан шалгах комиссын 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

Архивын үйл ажиллагааны чиглэлээр:

Нийслэлийн Засаг даргын 2015 оны A/172 дугаар захирамж "Байгууллагын архивын үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага, хадгалалтын горимыг тогтоож мөрдүүлэх журам", Нийслэлийн Засаг даргын A/177 дугаар захирамжаар батлагдсан "Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх журам", Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам, Салбар архивын үйл ажиллагааны нийтлэг журам, Нийслэлийн Засаг даргын 2013 оны A/452 дугаар захирамжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Дүүргийн архивын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 11/203 дүгээр албан бичгээр Нийслэлийн архивын газарт хүргүүлсэн.

Дүүргийн архивын дэргэдэх Баримт нягтан шалгах арга зүйн комиссын ажлын төлөвлөгөөг боловсруулан Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2023 онд дүүргийн архивт хөмрөг үүсгэгч төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 31 байгууллагын нөхөн бүрдүүлэлтийг хийхээр төлөвлөнөөс 19 байгууллагын данс бүртгэлийг дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-н хурлаар 3 удаа хэлэлцүүлэн баталж, данс бүртгэлийн дагуу баримтыг хүлээн авахад бэлэн болоод байна.

Төрийн архивт 2023 оны төлөвлөгөөт нөхөн бүрдүүлэлт хийгдэх өдөрүүллагууд:

- Худалдан авах ажиллагааны алба (2013-2020)
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс (2013-2020) он
- Дотоод аудитын алба (2013-2020) он
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв (2013-2020)
- Албан бус-Насан туршийн боловсролын төв (1992-2020) он
- Төхижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ (2013-2020)
- "Хан-Уул Агро"ОНӨААТҮГ (2011-2020) он
- "Хан-Уул Яармаг" ОНӨААТҮГ (2013-2020) он
- Газар зохион байгуулалтын алба (2013-2020) он
- Статистикийн хэлтэс (2002-2020) он
- 118 дугаар сургууль (2011-2020) он
- 134 дүгээр цэцэрлэг (2013-2020) он
- 189 дүгээр цэцэрлэг (2012-2020) он
- 190 дугаар цэцэрлэг (2012-2020) он

Төлөвлөгөөт бус өмнө оны 2 байгууллага:

- Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс (2010-2018) он
- Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн, үйлчилгээний хэлтэс (2010-2018) оны нийт 16 байгууллагад мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөг тогтмол өгч, данс бүртгэлийг хянан, стандартыг мөрдүүлэн ажиллаж байна.

Архивын Ерөнхий газрын даргын 2018 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан "Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам"-ын дагуу дүүргийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх эх үүсвэрийн жагсаалтад орсон дүүргийн харьяа 98 байгууллагын архивын тоон тайланг <http://burtgel.archives.gov.mn/> системд цахим хэлбэрээр шивэх ажлыг хугацаанд нь хийж дүн мэдээг нийслэлийн Архивын газарт 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 11/68 дугаар албан бичгээр биелэлтийг хүргүүлсэн.

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад үүссэн 2022 оны 11 хадгаламжийн нэгжийн 1022 баримт бүхий 1977 хуудастай захирамжлалын баримтыг сканердаж www.Arch.ulaanbaatar.mn системд шивж цахим хэлбэрт шилжүүлсэн. Үүнд:

- Засаг даргын "А" захирамж нийт 648 баримт бүхий 1394 хуудастай /7 боть/
- Засаг даргын "Б" захирамж нийт 78 баримт бүхий 86 хуудастай /1 боть/
- Засаг дарын Тамгын газрын даргын "А" тушаал нийт 103 баримт бүхий 210 хуудастай /1 боть/
- Засаг дарын Тамгын газрын даргын "А" тушаал нийт 193 баримт бүхий 287 хуудастай /1 боть/

НИЙТ 11 хадгаламжийн нэгжийн 1022 захирамжлалын баримтын нягтан шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Нөхөн бүрдүүлэлт: Дүүргийн архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн 72 байгууллагын

- Байнга хадгалах-7845 хн
- Түр хадгалах-28042 хн

➤ 70 жилийн 6784 хадгаламжийн нэгжийн бүртгэлийг нягтлан шалгаж, дүүргийн архивын хөмрөгийн нэгдсэн жагсаалтыг шинэчилсэн.


Хувийн хэргийн бүрдүүлэлт хийгдээгүй 18 байгууллагын хувийн хэргийн бүрдлийг ТААҮЗ-ын дагуу гүйцээж хийсэн.

Төрийн архивт хөмрөг үүсгэсэн 14 сургуулиин 27/21 хн, 20 цэцэрлэгийн 2324 хадгаламжийн нэгжийн дэлгэрэнгүй судалгаа, дүүргийн харьяа 121 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын нэгдсэн судалгааг гаргасан.

Хан-Уул дүүргийн архивын сан хөмрөт баримт нь хадгалагдаж буй 71 байгууллагын нэрс, баримтын нэр төрөл, оны хязгаарын дэлгэрэнгүй судалгаа, хөмрөгийн нэгдсэн жагсаалт, баримт шилжүүлсэн жагсаалтын шинэчлэн боловсруулсан.

Дүүргийн хөмрөг үүсгэгч 121 баигууллагын үндсэн болон өоломжит эх үүсвэрийн жагсаалтаас 2022-2026 онд нөхөн бүрдүүлэлт хийгдэх байгууллагуудын жагсаалтыг шинэчлэн дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-н хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

Дүүргийн салбар архив байгуулах ажлын хүрээнд 2023 онд төрийн архивын хадгаламжийн санд 23,666,000 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг худалдан авч архивын байрны стандарт нөхцлийг ханган ажиллаж байна.



Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Био-Асралт” өрхийн эмнэлэгийн байрны 1 давхрын баруун жигүүрт салбар архивын байрыг тохижуулан 2023 оны 04 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд төрийн архивын баримтыг нүүлгэх ажлыг зохион байгуулсан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуучин байрны 2 давхар ногоон байрны 1 давхарт байрлах төрийн архивын баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 14-16 өдрүүдэд нүүлгэн шилжүүлсэн.



Тус хадгаламжийн санд хадгалагдаж байсан дүүргийн хөмрөг үүсгэгч 72 байгууллагын 8151 байнга хадгалах баримт, 6 нягтруулсан шүүгээг зөөврөлсөн



Байгууллагын архив:

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадад 2022 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан, хуваарийн дагуу хэлтэс, албадаас баримтыг архивт хүлээн авч баяжилт хийгдсэн.

Үүнд:

- Байнга хадгалах - 115 хн
- 70 жил хадгалах - 19 хн
- Түр хадгалах - 557 хн
- Байгууллага дээр байнга хадгалах - 16 хн нийт 707 хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авч, төрөлжүүлэн цэгцэлж, дугаарлалт хийн бүртгэлжүүлсэн.

2023 онд хүлээн авсан баримтын тоо:

№	Хэлтэс, тасаг	Байнга хадгалах	Түр хадгалах	70 жил	Байгууллага дээр байнга	Нийт ХН тоо
1	2	3	4	5	6	7
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	18	101	3	2	124
2	Санхүү, төрийн сангийн хэлтэс	61	246			307
3	Хууль, эрх зүй, архивын хэлтэс	4	26		5	35
4	Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	13	4			17
5	Нийгмийн хөгжлийн хэлтэс	7	27			34
6	Тохиижит, нийтийн аж ахуйн хэлтэс	-	4		9	13
7	Агаарын бохирдолтой тэмцэх тасаг	-	3			3
8	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	1	6			7
9	Аж ахуй, өмчийн хэлтэс	6	140	15		161
10	Олон нийттэй харилцах алба	5	-	1		6
ХН тоо		115	557	19	16	707

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-д заасны дагуу Засаг даргын Тамгын газрын архив 2023 оны 3 дугаар улиралд төрийн архивын сан хомрот нөхөн баяжуулалт хийгдэх тул баримтын данс бүртгэлийг байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлаар хэлэлцүүлэн, нийслэлийн архивын газрын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар батлуулж, Байнга хадгалах 2009-2020 оны цаасан суурьт болон тусгай төрлийн баримтыг Нийслэлийн архивт хүлээлгэн өгөх ба тус ажлын хүрээнд байнга хадгалах-1258, түр хадгалах-3863, 70 жил хадгалах-170 хадгаламжийн нэгжийн данс бүртгэл үйлдэж Нийслэлийн архивын газрын мэргэжил арга зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх болтгол ажлыг хангасан.

Сургалт, мэргэжил арга зүй:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын, Хууль эрх, зүй архивын хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын хэлтэстэй хамтран “Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа” болон “Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх” сургалтыг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж тус дүүргийн Засаг даргын харьяа байгууллага, сургууль, цэцэрлэг, хороод зэрэг 103 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан 114 албан хаагч хамрагдсан.

Төрийн архивт хөмрөг үүсгэгч 31 байгууллага болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах ажлын хүрээнд “Байгууллагын үйл ажиллагааны

явцад үүссэн баримтыг эмхлэн цэгцлэх, цаасан болон цахим нөхөн бүрдүүлэлт хийх ажлын арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж ажилласан. Тус сургалтад нийт 29 албан хаагч хамрагдсан.

Дүүргийн архивын сан хөмрөгийн баримтыг судлах, мэдээлэл лавлагана, танин мэдэхүйн зорилгоор байгууллага, иргэдэд ашиглуулахтай холбогдсон үйл ажиллагаанд Архивын тухай хууль, Төрийн архивын тухай хууль, Төрийн, байгууллагын архивын ажлын үндсэн заавар, Төрийн архивын баримт ашиглалтын нийтлэг журам, эрх зүйн бусад холбогдох актыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Архивын баримтаас дотооддоо түр олгосон байдал:

Дүүргийн архиваас дотоод хэлтсүүдэд 118 баримтыг түр ашиглуулсан.

Үүнд:

- Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс-(2020-2022 оны)-27 ХН
- Санхүү, төрийн сангийн хэлтэс-(2021-2022 оны)-58 ХН
- Хууль, эрх зүй, архивын хэлтэс-(2018-2020 оны)-18 ХН
- Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс-(2019-2021 оны)-7 ХН
- Нийгмийн хөгжлийн хэлтэс-2022 оны -5 ХН
- Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс-2017 оны -1 ХН
- Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс-2020-2021 оны -2 ХН
- Аж ахуй, өмчийн хэлтэс-(2020-2021 оны)- 2 хадгаламжийн нэгж.

Төрийн архивын 7 хөмрөгийн баримтаас 12 иргэнд 1994-2014 оны 15 хадгаламжийн нэгжийн **16 хуудас**,

Малын "A" дансны 5 хөмрөгийн баримтаас 7 иргэнд 1995-2018 оны **76** хадгаламжийн нэгжийн **182 хуудас** архивын баримтаас лавлагана, хуулбарыг олгосон.

Байгууллагын архивын 4 данс бүртгэлийн 1994-2023 оны **142** хадгаламжийн нэгжээс **613 хуудас**,

Байгууллагын архиваас дотооддоо 118 баримтыг түр ашиглуулсан ба **225** баримтаас лавлагана хуулбарыг олгосон байна.

2.7 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал;

- ❖ Иргэдийн гаргасан өргөдөл, гомдлыг төрлөөр ангилж үзвэл:



Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлаар авч үзвэл:

Дүүргийн хэмжээнд

- Иргэний талд шийдвэрлэж хариу өгсөн - 1830
- боломжтүй тухай хариу өгч шийдвэрлэсэн - 289

- бүрэн барагдуулж шийдвэрлээгүй – 33
- Засаг даргын Тамгын газарт
 - Иргэний талд шийдвэрлэж хариу өгсөн - 1830
 - боломжгүй тухай хариу өгч шийдвэрлэсэн - 289
 - бүрэн барагдуулж шийдвэрлээгүй – 33

Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариу өгсөн хэлбэрийг авч үзвэл:



	Утсаар	Мессежээр	Албан бичгээр	Иргэнтэй уулзсан
ДҮҮРЭГ	1114 буюу 51,7%	353 буюу 16,5%	394 буюу 18,3%	291 буюу 13,5%
ЗДТГ	173 буюу 61,6%	24 буюу 8,5%	63 буюу 22,4%	21 буюу 7,5%

Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хан-Уул дүүрэг	Нийт өргөдөл		Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Шийдвэрлэлтийн дундаж хоног		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	2022 V/21	2023 V/21	2022 V/21	2023 V/21	2022 V/21	2023 V/21	2022 V/21	2023 V/21	2022 V/21	2023 V/21
ИТХ	2	2	2	1	0	0	02x 01ц 03м	22x 18ц 22м	0	26
ЗДТГ	321	314	765	296	19	0	05x 09ц 25м	07x 19ц 17м	14	7
Харьяа хэлтэс, алба, тасаг	1010	1443	926	1363	9	7	06x 21ц 48м	08x 04ц 53м	202	214
Дүүргийн өмчийт үйлдвэрийн газрууд	24	27	23	27			03x 22ц 53м	04x 16ц 05м	41	13
Хороод	62	184	48	177	1	1	07x 19ц 13м	05x 13ц 34м	87	93
Эмнэлэг	123	268	120	264			06x 19ц 52м	02x 08ц 20м	69	13
Сургууль, цэцэрлэг	14	31	14	31			00x 14ц 35м	02x 05ц 57м	0	15
Дүүргийн хэмжээнд /нийт/	1556	2269	1429	2144	10	8	06x 12ц 07м	07x 02ц 21м	413	381

Хугацаа хэтэрсэн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



Шийдвэрлэх явцад гаргасан зөрчлийн төрөл, байгууллагаар:

Зөрчлийн төрөл	Зөрчлийн тоо	Байгууллагаар	Зөрчлийн тоо
Бусад зөрчил	0	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	26
Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	46	Засаг даргын Тамгын газар	7
Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	82	Харьяа хэлтэс, алба, тасаг	214
Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	266	Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	13
Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	17	Хороод	93
Холбогдох файл хавсаргаагүй	0	Эмнэлэг	13
НИЙТ	381	Сургууль, цэцэрлэг	15
		Дүүргийн хэмжээнд/нийт/	381

Зөрчлийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



ХАМГИЙН ИХ ГОМДОЛ ИРСЭН ХЭЛТЭС

- Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтэс – 63 буюу 40,6 %
- Төрийн захиргааны удирдлагын хэлтэс – 26 буюу 16,8 %
- Тохижилт, ногоон байгууламжийн гүйцэтгэл, хяналтын хэлтэс – 25 буюу 16,1 %
- Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс – 16 буюу 10,3%
- Төлөвлөлт, гүйцэтгэл, мониторингийн хэлтэс – 15 буюу 9,7%

ГОМДЛЫН ТЭРГҮҮЛЭХ АГУУЛГА

- Орон сууцны 1-р давхарт байрлах үйлчилгээний тээриудын, ТҮЦ, павилён, ил задгай худалдаа үйлчилгээний тухай тухай – 32 буюу 19,39%
- Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаа, төлбөр хураамж, үнэ тарифын тухай – 27 буюу 16,36 %
- Нийтийн эзэмшигийн зам, талбай тохижилт, явган хүний зам, тохижилт, гэрэлтүүлэг, чимэглэлийн тухай – 22 буюу 13,33 %

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр:

Иргэдээс дүүргийн Засаг даргын харьяа, дэргэдэх хэлтэс, албан хаагчдад гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг бэлтгэн Засаг даргын болон Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд тус тус танилцуулсан.

Өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн болон шийдвэрлэх явцад зөрчил их гаргасан Засаг даргын харьяа, дэргэдэх 12 хэлтэс, албадад 7 удаагийн зөвлөмжийг албан бичгээр хүргүүлэн зөрчлийг арилгаагүй Засаг даргын дэргэдэх 2 хэлтсийн албан тушаалтанд журмын дагуу хариуцлага тооцох тухай 2023 оны 5 дугаар сарын 03 -ны өдрийн 03/737, 03/738 дугаар албан бичгээр дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Мөн хорооны 2 Засаг дарга, 3 зохион байгуулагчид “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын 13.4-т заасны дагуу арга хэмжээ авах санал хүргүүлсэн.

Сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтсүүдийн иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн дүүргийн Статистикийн хэлтсээс эрхлэн гаргадаг “Статистикийн мэдээлэл” гарын авлагад нийтлүүлж ажилласан.

Засаг дарга иргэдэд мөнгөн тусlamж үзүүлсэн талаар:

Дүүргийн иргэдийн Төлөөлогчдийн Хурлын Төргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Хан-Уул дүүргийн иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусlamж үзүүлэх тухай журам”-ыг хангуулан ажилласан.

Мөнгөн тусlamж хүссэн иргэдийн гэрээр хорооны нийгмийн ажилтан очиж нөхцөл байдлын үнэлгээ хийн баталгаажиж ирсэн нийт 55 иргэнд 19,450,000 (арван есөн сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийн нэг улаагийн буцалтгүй тусlamж олгох захирамжийн төслийг боловсруулсан.Үүнд:

- ✓ A/94 дүгээр захирамжаар нийт 19 иргэнд 7,900,000 төгрөг,
- ✓ A/159 дүгээр захирамжаар нийт 18 иргэнд 6,400,000 төгрөг,
- ✓ A/287 дугаар захирамжаар нийт 19 иргэнд 6,050,000 төгрөгийн буцалтгүй тусlamж олгох захирамжийн төслийг боловсруулсан.

Нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааны талаар:

“Нэг цэгийн үйлчилгээ”-ний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажилласан бөгөөд Нэг цэгийн үйлчилгээний төвөөр өдөрт 600-800 иргэн тогтмол үйлчилгээ авч, өргөдөл гомдол хүлээн авах, эд хөрөнгийн бүртгэл, гэрчилгээ олгох, гадаад паспорт хүлээн авах, олгох, хуулийн этгээдийн бүртгэл, гэрчилгээ олгох, иргэний бүртгэл, олголт, нотариат, кадастр, канон(зурагчин) зэрэг 13 цонхоор 69 төрлийн үйлчилгээ хүргэдэг. 2023 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 209,389 иргэн үйлчилүүлсэн.

Үүнээс гадна иргэдэд зориулан ТҮЦ машин, улсын бүртгэлийн хураамж, Газар, зохион байгуулалтын албаны хураамж, татвар, торгууль, шүүхийн тэмдэгтийн хураамж, вакцины бичиг, шинжилгээний хариу гэх мэт үйлчилгээг хялбар, шуурхай шийдэх боломжтой ГЭРЭГЭ киоск автомат машин ажиллаж, нийт 32773 иргэн үйлчилүүлсэн.

Нийт үйлчилүүлсэн иргэдийн тоо 2023 оны эхний хагас жилийн байдлаар (давхардсан тоогоор)

№	Үйлчилгээний төрөл	Эхний хагас жилийн байдлаар (өссөн дүнгээр)
1	Эд хөрөнгийн эрхийн бүртгэл	21871.00
2	Хуулийн этгээдийн бүртгэл	12062.00
3	Иргэний бүртгэл	9548.00
4	Гадаад паспорт	15674.00
5	Нотариат	12356.00
6	Канон, түргэн зурагчин	18417.00

7	Газрын кадастр	7302.00
	Нийт дүн	97230.00

Дүүргийн лавлагаа, мэдээллийн 77771965 тусгай дугаарын дуудлагын мэдээ:

Дүүргийн хэмжээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар 7896, үүнээс Засаг даргын Тамгын газарт 4253 дуудлага ирснийг холбогдох хэлтэс албад руу шилжүүлж мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан.

2.8 Байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил;

2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлаас бусад зардлыг батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хэмнэлт гаргах гэсний дагуу жижиг мөнгөн сангийн зарцуулах эрх нээгээгүй тул ЖМСан олгоогүй болно.


Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төрийн өмчит байгууллагууд болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудаас хүлээн авч нэгтгэж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”


3.1 Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;

Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах чиглэлээр:

“Хан-Уул дүүрэг цахим дүүрэг” болох зорилтын хүрээнд дүүргийн албан ёсны [/www.khanuul.mn/](http://www.khanuul.mn/) цахим вэб сайтыг шинэчлэн, иргэд төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй шуурхай авах нөхцөлийг бүрдүүллээ. Тухайлбал дүүргийн khanuul.mn цахим вэб сайтад Е-mongolia, Ulaanbaatar.mn, Авилгатай тэмцэх газар зэрэг дээд байгууллагуудын нийт 10 гаруй төрлийг албан ёсны цахим вэб сайтыг холбож, иргэд шууд холбогдон төрийн үйлчилгээг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлсэн.



Байгууллагын ил тод байдлын мэдээллийг шинэчилсэн талаар: Засаг даргын Тамгын газрын чиг үүргийн мэдээллийг цахим вэб сайтад ил тод, нээлттэй байршуулан Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын цахим вэб хуудсыг дүүргийн сайтад холбогдох мэдээ, мэдээллийг бүрэн шинэчилсэн. 164 мэдээ, мэдээллийг байршуулсан.



Мэдээллийн чиглэлээр: Монгол Улсын Засгийн газар, нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд хэвлэл мэдээллийн нийт 27 байгууллагатай хамтран ажилласан. /5 телевиз, 22 сайт/



Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, хороодын цаг үеийн үйл явдлын нийт 3134 мэдээллийг хянан боловсруулан хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн сүлжээгээр дамжуулан сурталчилсан. Тухайлбал шууд дамжуулалт 48, ярилцлага, сурвалжлага 56, тодруулга мэдээ 123.



Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын нийт 309 видео, 575 постер, 186 шторк, 45 рийл мэдээ, мэдээллийн 312 мэдээг тус тус бэлтгэн Хан-Уул Эко дүүрэг болон бусад мэдээллийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд шуурхай хүргэсэн.


Хан-Уул дүүрэгт өрнөсөн 7 хоногийн үйл ажиллагааны мэдээллийн "Эко дүүрэгт энэ 7 хоногт" гарчигтайгаар тоймлон 7 хоног бүрийн бямба гараг бүр бэлтгэн гаргаж хэвшсэн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 28 удаа тойм мэдээллийг бэлтгэсэн.

Мөн "Хан-Уул Эко дүүрэг" твиттер хаяг шинээр нээж, үйл ажиллагааны товч мэдээллийг тухай бүр нийтэлж хэвшсэн.



Цаг үеийн холбогдолтой нөлөөллийн КОНТЕНТ бэлтгэсэн талааар:

Хан-Уул дүүргийн Онцгой комисс болон дээд байгууллагын шийдвэр, хууль тогтоомжийг иргэдэд нээлттэй ойлгомжтой байдаар хүргэх зорилгоор ЭЭРЭГ нөлөөллийн контент, видео, зөвлөмжийг бэлтгэж, олон нийтэд түгээж эхэлсэн.




Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн танилцуулга бүхий сэтгүүлийг дүүргийн Засаг даргын 29 дэргэдэх хэлтэс албад, Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, 1-25 хороодод өгч ажилласан.

Төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар шуурхай хүргэх ажлын хүрээнд:

/KHANUUL.MN/ Хан-Уул дүүргийн албан ёсны www.khanuul.mn цахим вэб сайтын дэргэд “Хан-Уул Эко дүүрэг”, “Товч мэдээ-Эко дүүрэг”, “Хан-Уул дүүргийн иргэдийн бүлэг” зэрэг нийт 3 цахим хуудсыг хөтлөн нийслэл, дүүрэг болон дээд байгууллагуудын шийдвэр, төрийн үйлчилгээний мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж иргэдээс ирсэн асуултанд 24 цагаар тухай бүр нь хариулан ажиллаж байна.


Төрийн байллууллагын цахим вэб сайтад чатбот үйлчилгээг нэвтрүүлэн хөтлөлт хийсэн талаар: “Цахим дүүрэг” зорилтын хүрээнд дүүргийн албан ёсны khanuuil.mn цахим вэб сайтад “Чат-бот” үйлчилгээг анхлан нэвтрүүлж, Хан-Уул Эко дүүрэг цахим хуудсыг холбосон. Дээрх үйлчилгээг нэвтрүүлснээр төрийн албан хаагчдын ажлын ачаалал тодорхой хэмжээгээр буурч, төрийн үйлчилгээтэй холбоотой лавлагаа, мэдээллийг иргэдэд цахимаар тухай бүр шуурхай хүргэдэг болсон. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 21.201 иргэн www.khanuuil.mn цахим вэб сайтад хандан, 7203 иргэн чатбotoор асуулт асууж, 351 талархал, 102 гомдол санал тавьж, холбогдох чиг үүргийн байгууллагуудад дамжуулан шуурхай шийдвэрлэсэн.




“ХАН-УУЛ ЭКО ДҮҮРЭГ” цахим хуудаст нийт 821 мэдээ, 146 видеошторк, 396 постер мэдээллийг бэлтгэн оруулж, иргэдээс чатаар 1277 асуулт, коментоор 356 асуултанд тухай бүр нь хариулсан. Үүнээс 265 талархал, 125 гомдол, санал хүсэлт ирж, нийт 1,062,900 цахим хуудас руу хандаж, мэдээ, мэдээлэл авсан байна. Өмнөх онтой харьцуулахад тус хуудасны дагагчдын тоо 23,555 хүрч, өдөрт дунджаар 35 мянган хүн тус хуудаст хандан мэдээ, мэдээлэл тогтмол авдаг болсон.




“ТОВЧ МЭДЭЭ-ЭКО ДҮҮРЭГТ” цахим хуудаст дүүргийн өдөр тутмын мэдээлэл болон зөвлөгөө зөвлөмжийг товчоор хүргэдэг тус хуудаст нийт 536 мэдээлэл, 65 рийл, 82 стори оруулж, чатаар 2.595 , коментоор 568 асуулт тус тус ирснийг тухай бүр нь хариулан ажилласан. “Товч мэдээ-Эко дүүрэгт” цахим хуудас руу нийт 831.300 иргэн хандан мэдээ, мэдээлэл шуурхай авсан байна. Өмнөх онтой харьцуулахад тус хуудасны дагагчдын тоо 20,582 хүрч, өдөр тутам тус хуудас руу 22,514 иргэн хандаж, мэдээ, мэдээллийг авч байна.



“ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН БҮЛЭГ” дүүргийн албан ёсны цахим бүлгэмд нийт 985.602 мэдээ, видео, шторк, постер оруулж, 29,900 (+2400) гишүүнтэй болсон байна. Дунджаар +625,000 удаа иргэд хандаж, нийт 19,525 комент, чатаар ирсэнийг тухай бүр нь хариулж иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэсэн байна.



Зарим төрийн үйлчилгээний бүрдүүлэх материалын жагсаалт, албан хаагчидтай холбогдох утасны дугаар зэрэг иргэдэд нэн шаардлагатай мэдээллийг дүүргийн албан ёсны цахим вэб сайтаас иргэд гар утаснаасаа цаг алдалгүй авах боломжтой болсон. Тухайлбал тамхины зөвшөөрөл, эрхийг бичиг баримтыг сунгуулах гэх мэт.



Төрийн үйлчилгээтэй холбоотой мэдээ, мэдээлэл, зөвлөмж, видеог нөхөж болон ухраан үзэх боломжтой боллоо. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төрийн үйлчилгээний мэдээлэл, дээд байгууллагын хууль, тогтоомж, мэдээллийн видео, шторкыг нөхөж үсн, төрийн үйлчилгээг 24 цагаар тус цахим хуудаснаас тогтмоя авах боломжтой. Facebook, YouTube, Chatbot- зэрэг цахим хаягтай шууд холбогдож ажиллах технологийг нэвтрүүлэн төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг үе шаттай хийж байна.

Хүний нөөцийн чиглэлээр: Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон “5Ш” ажиллагаа зарлаж, авлигатай тэмцэх “шүгэл, шүүр, шувуу, шилжүүлэн авах, шилп” ажиллагааг хэрэгжүүлж байна.

“Шүүр” ажиллагааны хүрээнд;

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны ХЭГ/595 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй ЗДТГ-ын 10 албан хаагчийг 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон албан тушаалаас чөлөөлсөн, тусгай шалгалт өгөөгүй 7 албан хаагчид 2023.04.06-ны өдөр хууль тогтоомжид заасны дагуу Засаг даргын Тамгын газрын даргын мэдэгдэл өгсөн.

- Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны удирдах ажилтан 3, ерөнхий боловсролын сургуулийн захирал 9, цэцэрлэгийн 15 эрхлэгчид дүүргийн Засаг даргын мэдэгдэл тус тус өгсөн. Мэдэгдлийн дагуу албан хаагчдыг албан тушаалаас чөлөөлж, сүл орон тоог зохих журмын дагуу нөхөх сонгон шалгаруулалтыг захиалтыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн.

“Шүгэл ажиллагаа”-ны хүрээнд;

• Авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан Авлигатай тэмцэх газрын "...НЭГДҮЕ" соён гэгээрүүлэх аянд нэгдэж тв шторк, постерыг байгууллагын сайт, Хан-Уул Эко дүүрэг албан ёсны фэйсбууک хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилсан бөгөөд хороодын мэдээллийн самбарт зурагт хуудсыг байршуулсан.

"Шил ажиллагаа"-ны хүрээнд;

• Байгууллагын албан ёсны цахим хуудас www.khanuuil.mn -ны Ил тод булангийн Хүний нөөцийн удирдлагын ил тод цэсэнд 11 төрлийн мэдээллийн тухай бүр баяжуулан ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 4 төрлийн тв шторк, видео график, теле зохиомжийг дүүргийн www.khanuuil.mn цахим хуудасны авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод буланд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн.

❖ "Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодын төрийн албан хаагчийн хөгжил, нийгмийн баталгаа, ёс зүй, сахилга хариуцлагын чиглэлзэр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээний дагуу Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс алба, хороодын 350 албан хаагчдыг төрөөс баримталж буй бодлого, эрхэлж буй ажлын чиг үүргийн дагуу 15 удаагийн сургалтад хамруулж, арга зүйн дэмжлэг үзүүлсэн.

❖ Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс 4, 6, 11, 15, 17, 18, 19, 20, 21, 21, 22 дугаар хороодод ажиллаж, албан хаагчдын цаг ашиглалт, төрийн үйлчилгээ хэвийн явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан. Шалгалтаар 4, 11, 18 дугаар хороодын төрийн захиргааны албан хаагчдын цаг ашиглалт хангалтгүй, өглөө 08:00 цагт үйлчилгээ авахаар ирж буй иргэнд үйлчлэх төрийн албан хаагч байхгүй, хувийн чөлөө авсан, ЗДТГ явсан гэх тайлбар өгсөн. Дээрх хороодод цаг ашиглалт, ажлын байрны эмх цэгц, албан хаагчдын хувцаслалтыг сайжруулж, хорооноос үзүүлж буй төрийн үйлчилгээг 08:00-17:00 цагт хэвийн явуулах талаар шаардлага тавьсан.

Мэдээлэл технологийн чиглэлээр: Засаг даргын Тамгын газар болон 25 хорооны албан хаагчдын компьютер болон дагалдах техник хэрэгслийн засварын нийт 200 ажил, Иргэдэд үйлчлэх төв байрны 4,5,6 давхаруудын дотоод сүлжээг шинэчилсэн.

Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн 2, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн 2 мэргэжилтэн болон 9, 18 дугаар хорооны сүлжээний WiFi болон сүлжээний төхөөрөмжийг шинэчлэн сайжруулалтыг хийсэн. Шинээр байранд орсон 15, 16, 20, 21 дүгээр хорооны шилэн кабель татах ажлын төндэр 2023 оны 02 сарын 10-ны өдөр зарлагдаж, "Сонголт нар" ХХК шалгаран гэрээ байгуулсан бөгөөд 20, 21 дүгээр хорооны шилэн кабелийг татах ажлыг эхлүүлж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

Санхүү өмч бүртгэлийн чиглэлээр: Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, НББОУС-ын дагуу анхан шатны баримт болон холбогдо тушаал шийдвэрийг үндэслэн дүүргийн төсвийн хөрөнгөөр шинээр худалдан авсан нийт 44.562.700 төгрөгийн бараа материал, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2.299.793.705 төгрөгийн эд хөрөнгийг Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар данс бүртгэлд бүртгэсэн.

Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/52 дугаар тушаалаар хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан бөгөөд нийт 25 хорооны өмч эд хөрөнгийг тоолохоос 1-25 дугаар хороод, Засаг даргын дэргэдэх 5 хэлтэс, албадын 14 төрлийн өмч хөрөнгийг тоолсон. Мөн өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах талаар зөвлөмж зөвлөлгөө өгсөн.

Дүүргийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2022 оны А/867, А/1289, А/1629 дугаар тушаалаар актлагдсан нийт 9 автотээврийн хэрэгслийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт 2023 оны 05 дугаар сарын 2-нд хулээлгэн өгсөн.

Түрээсийн байртай /2023 оны 1 дүгээр сард түрээслэж байсан/ 3, 15, 17, 20, 21 дүгээр хороодын түрээс, цахилгаан, дулаан, усны гэрээнүүдийг холбогдох байгууллагуудтай нь шинэчлэн байгуулсан.

Мөн 4, 5, 6, 7, 8, 9, 16, 12, 14 дүгээр хороодын бохирын гэрээ, 12 дугаар хорооны иргэдэд үйлчлэх байрны дулаан, цахилгааны гэрээг тус тус шинэчлэн байгуулсан бөгөөд хороодын байрны түрээс, ашиглалтын зардалд нийт 341,690,423.61 төгрөгийн төлбөр тооцоо хийж өр төлбөргүй ажилласан.

Дүүргийн Θмч хамгаалах байнгын зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөг батлуулж, Засаг даргын Тамгын газар болон 25 хорооны албан хаагчидтай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулсан. Дүүргийн Θмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг нийт 10 удаа зохион байгуулж, 14 ажлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Засаг даргын Тамгын газрын үндсэн дансаар 1318 ширхэг баримтаар 5.234.928.019.5 төгрөгийн гүйлгээг хянан баталгаажуулсан байна.

Хүснэгтээр харуулбал:



Дүүргийн хөрөнгө оруулалтын харилцахын дансаар 15 компанийн 3.620.643.778 төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулсан.



Нэмэлт санхүүжилтийн харилцахын дансны 3 ширхэг баримтаар 3.591.986 төгрөгийн гүйлгээг хянан баталсан.

Санхүүгийн анхан шатны баримтад тулгуурлан бараа материал, хангамжийн 480 ширхэг баримтаар 589.448.157 төгрөгийн орлогын гүйлгээ хянасан.

БАРАА МАТЕРИАЛЫН ОРЛОГО /ТӨГРӨГӨӨР/



Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ашиглаж буй 28.700.000 төгрөгийн хангамжийн материалыг хариуцсан албан хаагчдад шилжилт хөдөлгөөнөөр хянасан


ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН /ТӨГРӨГӨӨР/



Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, НББОУС-ын дагуу анхан шатны баримт болон холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн 2.763.705.829 төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж ажилласан. Үүнээс:

- Нийслэлийн хөрөнгө оруулалтаар -2.651.517.029 төгрөг
- Дүүргийн төсвийн хөрөнгөөр -112.188.800 төгрөг

ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ОРЛОГО /ТӨГРӨГӨӨР/




Ажлаас чөлөөлөгдсөн болон ажилд шинээр томилогдсон албан хаагчдын эд хөрөнгийг хүлээндээж хяналт тавьж ажилласан.

Хөрөнгө оруулалтын барьцаа данснаас 2023 оны эхний хагас жилийн байдлаар 6 аж ахуйн нэгж, байгууллагын 58.574.721 төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөхөд хяналт тавьсан.


2023 оны 1-4 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуулийн хугацаанд нь Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН САРЫН МЭДЭЭ /ӨССӨН ДҮНГЭЭР/




Засаг даргын Тамгын газрын болон 25 хорооны нийт 134 төрийн албан хаагч, хороодын 234 хэсгийн ахлагчийн цалин, 9 албан хаагчийн ээлжийн амралтад тус тус хяналт тавьж, баталгаажуулан ажилласан.

ЦАЛИН ХӨЛС, НЭМЭГДЭЛ УРАМШУУЛАЛ



2023 оны эхний хагас жилийн байдлаар бараа материалын 715 баримтаар нийт 531.468.521 төгрөгийн зарлагын гүйлгээг шаардах хуудасны дагуу хянасан.

БАРАА МАТЕРИАЛЫГ ДАНС БҮРЭЭР ХАРУУЛБАЛ




2023 оны 1 дүгээр улирлын Хөрөнгө оруулалтын барьцаа сан, Орон нутгийн хөгжлийн сан, Хөрөнгө оруулалтын сан, Байгаль хамгаалах сангийн санхүүгийнтайлант хуулийн хугацаанд нь Санхүү, төрийн сангийн хэлтэст тушааж баталгаажуулсан.

Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, жолооч нарын замын хуудсыг үндэслэн 46.563.000 төгрөгийн шатахууны тооцоог бодож хяналт тавьсан.

Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/52 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг эд хөрөнгийн хагас жилийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан бөгөөд нийт 9 хэлтэс болон 25 хорооны албан хаагчдын эд хөрөнгийг тоолсон.

Татварын тайланг 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар гаргаж хугацаанд нь илгээн, автомашины татвар болон бусад татвар хураамжуудыг цаг тухай бүр төлөлт хийн татварын өр үүсгэлгүй ажилласан.

БАРЬЦАА ЧӨЛӨӨЛӨЛТ /ТӨГРӨГӨӨР/



3.2 Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангасан буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн;

Хуулийн хугацаанд төсөв, гүйцэтгэл дээр нийт 47 мэдээлэл, хөрөнгө оруулалт болон тендер, худалдан авалт дээр 20 мэдээллийг давтагдсан тоогоор нийт 67 мэдээлэл <https://shilendans.gov.mn/> сайтад байршуулан ажиллаж байна. Мөн <https://khanuul.mn/> сайтын мэдээллийн ил тод байдалын хэсэгт дүүргийн төсөв, санхүүтэй холбоотой бүх мэдээллийг тухай бүрт нь шинэчлэн байршуулж байна.

Бүртгэлийн үйлчилгээний талаар: Нэгтгэлийн программд 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан өгвөл зохих нийт 18,159 аж ахуйн нэгж, байгууллагаас 14,621 тайлан буюу 80.5%-ийг цахим системээр ирүүлсэн. Үүнээс 13,5/4 байгууллага буюу 74.8%-ийг баталгаажуулж, 1047 байгууллагын алдаатай болон аудитын байгууллагын нэрийн баталгаажуулалт хийгдээгүй тайланг буцаасан бөгөөд 2023 оны 06 сарын 08-ны өдрийн байдлаар завсрлын тайлан-37, запруултын тайлан-79, татан буугдсан-21 байгууллагын тайланг тус тус хүлээн авч, 3250 гаруй аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд арга зүйн зөвлөгөө өгөн ажилласан.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиин дагуу 4 аж ахуйн нэгж, байгууллагуудын нягтлан бодогч нарт шийтгэл оногдуулж нийт 5,200,000 төгрөгийг төсөвт төвлөрүүлэн, зөрчлийг арилгуулан ажилласан. Сар бүр Прокурорын газарт Шийтгэл оногдуулалтын мэдээг хүргүүлж байна.

2022 оны жилийн эцсийн тайлангийн нэгтгэлийг 2023 оны 4 дүгээр сарын 15-өдөр Сангийн яамны Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын газар болон Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хугацаанд нь хүрүүлсэн.

Сангийн яамны Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн А.Дайриймаа, Баянзүрх дүүргийн Бүртгэлийн мэргэжилтэн С.Нямжаргал нартай хамтран Миндүг Аудит ХХК, Цэгцтөв Богд Аудит ХХК, Сэц Түшиг Аудит ХХК, Төгс суурь стандарт Аудит ХХК, Пи Кей ЭФ Монголия Аудит ХХК, YNHT Аудит ХХК, Интер Аудит ХХК, Релаэнс Секюритиз Аудит ХХК, БДО Аудит ХХК, Хаан соёмбо аудит ХХК, Севиллия Аудит ХХК-д тус тус аудитын чанарын хяналтыг хийж үйцэтгэсэн.

Санхүүжилт олгосон талаар:

Орон нутгийн байгууллагуудад олгосон санхүүжилт: 2023 оны дүүргийн орон нутгийн 33 байгууллага, хөтөлбөр, зардлын төсвийн сар, улирлын хуваарийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаэр батлагдсан төсвийн дагуу боловсруулж хэлтсийн даргаар хянуулсан, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж тухайн байгууллагад хүргүүлэн хяналт тавьж ажилласан. Төсвийн орлого, зарлагын жилийн болон сар, улирлын хуваарийг төсвийн төлөвлөлтийн Фискал програмд байгууллага бүрээр оруулан нэгтгэж, Нийслэлийн ЗДТГ-ын СТСХ-т илгээн байгууллагуудын төсвийн зарцуулах эрхийг нээлгэж зарлагын гүйлгээ хийх нөхцлийг ханган 01-05 дугаар саруудын санхүүжилтийг хуваарилсан.

Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны орлого, даатгалын төлбөр, нэр данс зөрүүгийн болон бусад орлого, нэмэлт санхүүжилт, улсын төсвийн байгууллагуудын санхүүжилт, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогыг эдийн засгийн ангилал, хөтөлбөр зориулалт тус бүрээр задалж нээх гүйлгээг тухай бүрд хийж гүйцэтгэв.

Нийгмийн салбарын байгууллагуудад олгосон санхүүжилт: Нийгмийн салбарын байгууллагуудын байр ашиглалтын тогтмол зардлын 10,199.8 сая төгрөгийн батлагдсан төсвийг байгууллага тус бүрээр төсвийн сар, улирлын хуваарийг хийж батлуулан, зарцуулах эрхийг хуваарийн дагуу нээн, төсвийн гүйцэтгэлд сар бүр хяналт тавин ажилласан. Эхний 5 сарын байдлаар 4,793.1 сая төгрөгийн тогтмол зардлыг төсвийн хуваариар сар бүр хийж, батлуулан зарцуулах эрхийг татуулан, санхүүжилтийг хугацаанд нь олгуулан ажилласан.

Төрийн сангийн үйлчилгээний талаар: Төрийн сан банк нь харилцагч төсөвт байгууллагуудын дансны нэгдсэн жагсаалт гаргаж, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдэд хуваарилан, Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 2023 оны 1 дүгээр сарын 02-ны

өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 9,254 ширхэг 116,552.2 сая төгрөг, цахимаар 6,222ш 57,408.4 сая төгрөгийн гүйлгээ, нийт 15,476ш 173,960.7 сая төгрөгийн төлбөр тооцоог хянан баталгаажуулсан.

Төсөвт байгууллагуудын гарын үсийн баталгаат мажнын дагуу 17 төсвийн шууд захирагч, 24 нягтлан бодогчоос журмын дагуу шинэчлэн авсан. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд байгууллагыг ажлын 8 цагт багтаан бэлтгэн нийлүүлэгчээр 115 байгууллага болон хувь хүн бүртгэсэн.

Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд орон нутгийн байгууллагууд 17, орон нутгийн төсвийн цэцэрлэг 31, сургууль 23, нийт 71 байгууллагын мэдээ нэгтгэгдэн, орон нутгийн төсвийн цэцэрлэг, сургууль болон орон нутгийн байгууллагуудын 01-05 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Сангийн яамны програмтай тулган баталгаажуулсан ажилласан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ “Бусад мэдээлэл”

4.1 Холбогдох чиг үүргийн хүрээнд шинээр санаачлан хэрэгжүүлсэн болон онцлог ажил, арга хэмжээ;

- “Бүтээгч Хан-Уулчууд-2023” өдөрлөгийн арга хэмжээ:

Хан-Уул дүүргийн Засаг даргын санаачилгаар төр, хувийн хэвшлийн иргэн, аж ахуйн нэгж байгууллагудтай хамтран зохион байгуулсан “Бүтээгч Хан-Уулчууд-2023” нээлттэй өдөрлөгийг тус дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Мөсөн өргөө-Steppe arena”-ийн гадна талбайд 2023 оны 06 дугаар сарын 04-ний өдөр амжилттай зохион байгуулсан. Ажлын хэсгээс өгсөн чиглэлийн дагуу дээрх арга хэмжээнд төрийн захиргааны 10 байгууллагын 141 албан хаагчийг хамруулан 89 нэр төрлийн үйлчилгээг 6220 иргэнд хүргэж үйлчилсэн.



Хан-Уул дүүргийн бүтээн байгуулалт 2021-2022 оны фото мэдээллийн сэтгүүлийг ХЭВЛЭМЭЛ болон QR ЦАХИМ хэлбэрээр бэлтгэн гаргасан.

Хан-Уул дүүрэгт 2021-2022 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн бүтээн байгуулалт, тохиижилтын ажлын бүрэн багтаасан фото мэдээллийн сэтгүүлийн эхийг бэлтгэн иргэдэд мэдээ, мэдээллийг шуурхай хүргэсэн. Бүтээн байгуулалтын бүх мэдээлэл багтсан тус сэтгүүлд нийт **2000-3500** орчим зураг, **319** орчим мэдээлэл багтсан бөгөөд QR кодтой тус фото сэтгүүлийг цахим хэлбэрт хувирган дүүргийн **30 гаруй** мянган иргэдэд цахимаар хүргэх ажлыг санаачлан зохион байгууллаа.



Хороодод зөвлөн туслах арга хэмжээ:

Хан-Уул дүүргийн 21 хорооны ажилтан, албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүй, дотоод ажлын эмх цэц, мэргэшшийн үр чадвартай ахиц гаргах зорилгоор Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн дүүргийн 21 хороодод зөвлөн туслах ажлыг Тамгын газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр баталсан удирдамжийн дагуу зохион байгуулсан.

Зөвлөн туслах ажлыг зохион байгуулснаар хорооны өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, төрийн албаны стандартын хэрэгжилт хангагдан, иргэдэд үзүүлэх төрийн анхан шатны үйлчилгээ сайжирч, иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ.



Тус Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд дүүргийн Засаг даргын нэрэмжит 3 төрөлт спортын арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Спорт арга хэмжээнд 35 аж ахуйн нэгжийн 300 гаруй ажилтан, албан хаагчид оролцсон. Мөн "Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон харьяа байгууллагад дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ын төслийг боловсруулан нийслэлийн Засаг даргаар батлуулахаар Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 06-ны 06/360 тоот албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.



❖ Дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын видео шторкийг бэлтгэн цахим сайтуудаар дамжуулан иргэдэд сурталчилсан.

